

**Монголын Усан Спорт
Сонирхогчдын Холбоо**

**ЗАДГАЙ УСАНД
СЭЛЭЛТИЙН
ТЭМЦЭЭНИЙ
ДҮРЭМ**

2026 ОНЫ 06 САРЫН 24-НИЙ ӨДРӨӨС
ХҮЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛНЭ

**МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБООНЫ
ЗАДГАЙ УСАНД СЭЛЭЛТИЙН ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ**

1. Задгай усанд сэлэлтийн тэмцээн	2
2. Шүүгчдийн бүрэлдэхүүн	2
3. Гараа	10
4. Тэмцээн	13
5. Тэмцээний бариа.....	18
6. Холимог багийн төрөл	19
7. Хасагдах 3 км төрөл	20
8. Насны ангилал ба оролцох эрх	21
9. Бүртгэл ба гарааны мэдүүлэг	21
10. Усны хувцас, технологи бусад хэрэгсэлд тавигдах шаардлага	22
11. Тэмцээний үеэр тамирчдыг таних тэмдэглэгээ	23
12. Задгай усанд сэлэлтийн байгууламж, тоног төхөөрөмж	23
13. Усны чанар ба тэмцээний талбарын зохион байгуулалт	28
14. Задгай усанд сэлэлтийн эмнэлэгийн болон аюулгүй байдлыг шаардлага	33
15. Хавсралтууд.....	37
15.1 Хавсралт 1 – Замын зураглал	38
15.2 Хавсралт 2 – Зам дагуу байрлах завьнуудын байршлын зураглал.....	39
15.3 Хавсралт 3 – Гарааны тавцан, Тэжээлийн тавцан, Хөвөгч тэмдэглэгээний зураглал	40
15.4 Хавсралт 4 - Барианы болон дундын хаалганы зураглал	41

НЭГ. ЗАДГАЙ УСАНД СЭЛЭЛТИЙН ТЭМЦЭЭН

1.1 Энэхүү дүрэм нь МУССХ-ны болон түүний зөвшөөрлийн дагуу зохион байгуулагдах бусад бүх тэмцээнд хамаарна.

1.2 Задгай усанд сэлэлт гэдэг нь нуур, тэнгис, далай, усан суваг болон бусад ил задгай усан орчинд явагдах сэлэлтийн тэмцээнийг хэлнэ.

1.3 Монголын задгай усанд сэлэлтийн хөтөлбөр:

Эрэгтэй	Эмэгтэй	Багийн буухиа
10 км	5 км	Холимог буухиа 4 х 1500 м
5 км	3 км	Холимог буухиа 4 х 500 м
1,5 км	1 км	

1.4 МУССХ-ны Залуучуудын задгай усанд сэлэлтийн тэмцээний хөтөлбөр:

Нас	Хөвгүүд	Охид	Багийн буухиа
14-15 нас	0,5-1,5 км	0,5-1 км	Холимог буухиа 4 х 500 м
16-17 нас	1-3 км	1-2 км	Холимог буухиа 4 х 1000 м
18-19 нас	1-5 км	1-3 км	Холимог буухиа 4 х 1500 м

1.5 Аливаа тэмцээний зохион байгуулах хороо МУССХ-той зөвлөлдсний үндсэн дээр тэмцээнийг дээрхээс өөр зайд зохион байгуулж болно.

ХОЁР. ШҮҮГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН

2.1. Задгай усанд сэлэлтийн тэмцээний зохион байгуулах хороо нь тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүнийг дор хаяж дараахи байдлаар томилно:

2.1.1. Нэг (1) Ерөнхий шүүгч (төрөл тус бүрт);

2.1.2. Гурван (3) шүүгч, мөн оролцогчдын тооноос хамааран нэмэлт шүүгчид томилж болно. Хамгийн багадаа 20 тамирчин тутамд нэг (1) шүүгч байна;

2.1.3. Нэг (1) Ахлах цагчин, хоёр (2) цагчин (хэрэв автомат шүүлтийн төхөөрөмж болон барианы видео бичлэг ашиглаж байгаа бол зөвхөн нэг (1) цагчин томилох бөгөөд тэр нь Ахлах цагчин шүүгчийн үүргийг давхар гүйцэтгэнэ);

2.1.4 Нэг (1) Ерөнхий барианы шүүгч, хоёр (2) барианы шүүгч;

2.1.5. Нэг (1) Аюулгүй байдлын ажилтан;

2.1.6. Нэг (1) Эмнэлгийн ажилтан;

2.1.7. Нэг (1) Зам хариуцсан ажилтан;

2.1.8. Нэг (1) Бүртгэлийн ажилтан (Clerk of the Course).

2.1.9. Нэг (1) Тэмцээний явцын шүүгч (тамирчин бүрт нэг; зөвхөн 10 км-ээс урт зайд, тойрог замаар зохион байгуулагдаагүй тэмцээнд);

2.1.10. Нэг (1) Эргэлтийн шүүгч (замын чиглэл өөрчлөгдөх бүрт);

2.1.11. Нэг (1) Тэжээлийн тавцангийн шүүгч (тэжээлийн тавцан бүрт);

2.1.12. Нэг (1) Буухиа төрлийн шүүгч;

2.1.13. Нэг (1) Гарааны шүүгч;

2.1.14. Нэг (1) Зарлагч;

2.1.15. Нэг (1) Нарийн бичиг шүүгч - Recorder

2.1.16. Нэг (1) Видео хяналтын шүүгч.

2.2. Шүүгч нь нэгэн зэрэг хоёр ба түүнээс дээш үүргийг давхар гүйцэтгэхгүй. Хэрэв тухайн албан тушаалтны хариуцсан үүрэг бүрэн биелсэн бол өөр үүрэгт томилогдон ажиллаж болно.

2.3. Энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол шүүгч бүр өөрийн чиг үүргийн хүрээнд бие даан, хараат бус шийдвэр гаргана.

2.4. Хэрэв шүүгч өөрийн хариуцсан үүргийн хүрээнд дүрэм зөрчсөн үйлдэл илрүүлбэл дараах арга хэмжээг авна.

1. Зөрчлийг бүртгэн тэмдэглэх

2. Нэн даруй Ерөнхий шүүгчид мэдэгдэх

3. Тэмцээн дууссаны дараа гарын үсэг зурсан зөрчлийн маягтыг Ерөнхий шүүгчид хүргүүлэх

2.5. Ерөнхий шүүгч

2.5.1. Ерөнхий шүүгч нь тэмцээний бүх шүүгчдийг удирдан зохион байгуулах, хянах бүрэн эрхтэй байна.

2.5.2. Ерөнхий шүүгч тэмцээний явцад бүх шүүгчдийг өөрсдийн байрлалд ажиллаж байгаа эсэхийг хянаана. Шаардлагатай бол үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон, эсхүл хангалтгүй ажиллаж байгаа гэж үзсэн аливаа шүүгчийг солих эсвэл нэмэлт шүүгчийг томилж болно.

2.5.3. Ерөнхий шүүгч нь МУССХ-ны Тэмцээний дүрэм болон энэхүү дүрэмд заасан аливаа зөрчил гарсан эсэхийг тогтоох бүрэн эрхтэй бөгөөд тухайн тэмцээнтэй холбоотой бүх асуудлыг шийдвэрлэнэ.

2.5.4. Хэрэв тамирчдын болон шүүгчдийн аюулгүй байдалд эрсдэлтэй нөхцөл үүсвэл Ерөнхий шүүгч нь Аюулгүй байдлын ажилтан, Эмнэлгийн ажилтан болон Холбооны төлөөлөлтэй зөвлөлдсөний үндсэн дээр тэмцээнийг зогсоож болно.

2.5.5. Ерөнхий шүүгчийн тэмцээний гараатай холбоотой үүргийг энэ дүрмийн 3 дугаар зүйлд заасан.

2.5.6. Ерөнхий шүүгч нь тамирчин болон буухиа багийн гишүүн дүрэм зөрчсөн нь тогтоогдвол тухайн тамирчинд зөрчил ногдуулах эсвэл тэмцээнээс хасах шийдвэр гаргаж болно.

2.5.7. Ерөнхий шүүгч зарим тохиолдолд тэмцээн дууссаны дараа ч хасах шийдвэр гаргаж болно.

2.5.8. Ерөнхий шүүгч тэмцээний өмнө болон тэмцээн дууссаны дараа доорхи албан тушаалтнуудаас тайлан авна:

- Бүртгэлийн ажилтан
- Нарийн бичиг шүүгч
- Зам хариуцсан ажилтан
- Аюулгүй байдлын ажилтан

Ингэж бүх тамирчид бүрэн бүртгэгдсэн эсэхийг баталгаажуулна.

2.5.9. Барианы цаг болон тамирчдын эзэлсэн байр зөрүүтэй гарсан тохиолдолд Ерөнхий шүүгч энэ дүрмийн 3 дугаар зүйлийн 12.4-д заасныг баримтлан шийдвэр гаргана.

2.5.10. Ерөнхий шүүгч дүрэм зөрчсөн талаарх бүх маягтыг хүлээн авч хянаана.

2.5.11. Хэрэв видео туслах шүүгчийн систем ашиглаж байгаа бол тэмцээн дууссаны дараа дүрмийн зөрчлийг шалгаж шаардлагатай арга хэмжээг авна.

2.6. Шүүгч

2.6.1 Энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол шүүгч нь дүрмийн зөрчил гарсан эсэхийг тогтоох эрхтэй.

2.6.2 Шүүгч нь өөрийн биечлэн ажигласан дүрмийн зөрчлийг үндэслэн тухайн тамирчныг тэмцээнээс хасах эрхтэй.

2.6.3 Шүүгч нь Зам хариуцсан ажилтан болон Аюулгүй байдлын ажилтантай хамтран тэмцээн эхлэхээс өмнө тэмцээний зам болон тэмдэглэгээг шалгана.

2.7. Гарааны шүүгч

2.7.1 Ерөнхий шүүгчийн өгсөн дохионы дараа гарааны шүүгч нь энэхүү дүрмийн 3 дугаар хэсэгт заасны дагуу тэмцээнийг эхлүүлнэ.

2.8. Ахлах цагчин шүүгч

2.8.1 Ахлах цагчин шүүгч нь энэхүү дүрмийн 2.1.3-д зааснаас бусад тохиолдолд гараа болон барианд дор хаяж хоёр (2) цагчин шүүгчийг ажиллуулна.

2.8.2 Ахлах цагчин шүүгч нь тэмцээн эхлэхээс 15 минутын өмнө бүх шүүгчдийн цагийг албан ёсны цагийн төхөөрөмжтэй тааруулж, шалгана.

2.8.3 Ахлах цагчин шүүгч нь цагчин шүүгч тус бүрээс тамирчдын бүртгэгдсэн цагийг авч, шаардлагатай бол цагийг шалгаж, тамирчдын албан ёсны цагийг баталгаажуулан бүртгэнэ.

2.9. Цагчин шүүгч

2.9.1. Цагчин шүүгчид бүх тамирчдын цагийг хэмжинэ. Ашиглах цаг нь санах ой болон мэдээлэл сэргээх боломжтой байх бөгөөд зохион байгуулагч байгууллагын шаардлагад нийцсэн баталгаажсан нарийвчлалтай байна.

2.9.2 Цагчин шүүгч нь гарааны дохио өгөх үед цагийг эхлүүлж, тухайн тамирчин барианд орох үед (эсвэл Ахлах цагчин шүүгчийн зааврын дагуу) цагийг зогсооно.

2.9.3 Тамирчин барианд орсны дараа цагчин шүүгч нь тухайн тамирчны цагийг нэн даруй тэмдэглэн, Ахлах цагчин шүүгчид өгнө. Шаардлагатай бол Ахлах цагчин шүүгчид цагийг шалгуулах үүрэгтэй.

2.10. Барианы ахлах шүүгч

2.10.1 10 км-ээс урт зайтай тэмцээнд Барианы ахлах шүүгч нь тэмцээний явцын шүүгч бүрт дагалдах завийг (Escort Craft) хуваарилж, тэдэнд үүрэг чиглэл өгнө.

2.10.2 Барианы ахлах шүүгч нь барианы шүүгч бүрийг байрлалд нь томилж, тэмцээн дууссаны дараа тэднээс гарын үсэг бүхий үр дүнгийн хуудсыг хүлээн авч, албан ёсны байр эзлэлтийг тогтоон Нарийн бичиг шүүгчид (Recorder) дамжуулна.

2.10.3 Тэмцээний явцад шүүгчдээс ирүүлсэн шийдвэрийг Барианы ахлах шүүгч барианы шүүгч нарт дамжуулж бүртгэнэ.

2.10.4 Барианы ахлах шүүгч нь дараах байдлаар илэрсэн дүрмийн зөрчлийг бүртгэж, Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

- Өөрийн биечлэн ажигласан
- Барианы шүүгч ажиглан мэдээлсэн (Эдгээр нь зөвхөн барианы бүсэд гарсан зөрчил байна)

2.11. Барианы шүүгч

2.11.1 Барианы шүүгчид барианы шугамтай нэг шугамд байрлах бөгөөд барианы хавтан эсвэл барианы шугамыг тодорхой харах боломжтой байрлалд байна.

2.11.2 Барианы шүүгчид тамирчин барианд орсны дараа тамирчдын эзэлсэн байрыг тэмдэглэнэ. Барианы шүүгчид тухайн тэмцээнд цагчин шүүгчийн үүргийг давхар гүйцэтгэхгүй.

2.11.3 Барианы бүсэд гарсан дүрмийн зөрчлийг биечлэн ажигласан тохиолдолд тэмдэглэлийн хуудсанд бүртгэж, Барианы ахлах шүүгчид мэдээлнэ.

2.12. Тэмцээний явцын шүүгч

2.12.1. Тэмцээний явцын шүүгч бүрийг сугалаагаар томилж, тухайн шүүгчийг дагалдах завинд (Escort Craft) байрлуулна. Ингэснээр шүүгч өөрт оногдсон тамирчныг тэмцээний туршид ажиглах боломжтой байна.

2.12.2. Тэмцээний явцын шүүгч нь энэхүү дүрмийн шаардлагууд мөрдөгдөж байгаа эсэхийг хянана. Хэрэв дүрэм зөрчсөн үйлдэл илэрвэл бичгээр тэмдэглэж, аль болох богино хугацаанд Ерөнхий шүүгчид мэдэгдэнэ.

2.12.3. Тэмцээний явцын шүүгч нь өөрт оногдсон тамирчин:

- Шударга бус давуу байдал олж авахгүй байх
- Бусад тамирчинд санаатайгаар саад болохгүй байх шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянана.

Шаардлагатай тохиолдолд шүүгч тамирчдад 4.1.5–4.1.7 дугаар зүйлд заасны дагуу зай барихыг анхааруулж болно.

2.12.4 Ерөнхий шүүгчийн тогтоосон хугацааны хязгаар дууссан тохиолдолд (энэ дүрмийн 4.5.2-т заасны дагуу) тэмцээний явцын шүүгч тухайн тамирчныг уснаас гаргах шийдвэр гаргах эрхтэй.

2.13. Эргэлтийн шүүгч

2.13.1 Эргэлтийн шүүгч нь тамирчид тэмцээний удирдамжид заасан болон Техникийн/Багийн ахлагчдын хурлын үеэр тэмцээний өмнөх аюулгүй байдлын танилцуулгад тайлбарласан замын эргэлтүүдийг зөв гүйцэтгэж байгаа эсэхийг хянах боломжтой байрлалд ажиллана.

2.13.2 Эргэлтийн шүүгч нь эргэлт болон замын чиглэл өөрчлөхтэй холбоотой дүрэм зөрчсөн тохиолдлыг тэмдэглэлийн хуудсанд бүртгэж, нэн даруй Ерөнхий шүүгчид мэдэгдэнэ.

2.13.3 Тэмцээн дууссаны дараа Эргэлтийн шүүгч нь гарын үсэг зурсан тэмдэглэлийн хуудсыг Нарийн бичиг шүүгчид (Recorder) шуурхай хүргүүлнэ.

2.14 Тэжээлийн тавцангийн шүүгч

2.14.1 Тэжээлийн тавцангийн шүүгч нь тэжээлийн тавцан дээрх тамирчдын дэмжих багийн гишүүдийн үйл ажиллагааг зохион байгуулж, тэжээл өгөх ажиллагаа (ус, ундаа, тэжээл болон бусад хэрэглэгдэхүүн) нь дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхийг хянана. Энэ үйл ажиллагаа нь энэхүү дүрмийн 4.4 дүгээр зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

2.15. Буухиа гарааны шүүгч

2.15.1 Буухиа гарааны шүүгч нь буухиа солилцооны тавцан буюу солилцооны бүсэд явагдах үйл ажиллагааг хянаж, тамирчдын солилцоо нь дүрмийн дагуу (энэ дүрмийн 6.1.7 дугаар зүйлд заасны дагуу) хийгдэж байгаа эсэхийг шалгана.

2.16. Аюулгүй байдлын ажилтан

2.16.1 Аюулгүй байдлын ажилтан нь тэмцээний явцад аюулгүй байдлыг хангахтай холбоотой бүх асуудлыг хариуцах бөгөөд энэ дүрмийн 14 дүгээр хэсэгт заасны дагуу Ерөнхий шүүгчид тайлагнана.

2.16.2 Аюулгүй байдлын ажилтан нь тэмцээн эхлэхээс өмнө тэмцээний замыг бүхэлд нь, ялангуяа гараа болон барианы бүсийн аюулгүй, саадгүй эсэхийг шалгана.

2.16.3 Аюулгүй байдлын ажилтан нь тэмцээний үеэр тамирчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор дагалдах завь (Escort Craft) болон аюулгүй байдлын завь (Safety Craft) хангалттай тоотой, шаардлагатай хүчин чадалтай байгааг баталгаажуулна.

2.16.4 Тэмцээн эхлэхээс өмнө Аюулгүй байдлын ажилтан нь тамирчдад түрлэгийн өөрчлөлтийн талаарх тооцоолсон цагийн мэдээлэл, мөн түрлэг болон урсгалын тамирчны хөдөлгөөнд үзүүлэх нөлөөг харуулсан замын зураглал танилцуулна.

2.16.5 Аюулгүй байдлын ажилтан нь Эрүүл мэндийн ажилтантай хамтран тухайн нөхцөл байдал тэмцээн зохион байгуулахад тохиромжгүй гэж үзвэл Ерөнхий шүүгчид зөвлөмж өгч, шаардлагатай бол замын өөрчлөлт эсвэл тэмцээний зохион байгуулалтын өөрчлөлтийн талаар санал гаргана.

2.16.6 Аюулгүй байдлын ажилтан нь тэмцээний явцад усны температурыг тогтмол хянаж, энэхүү дүрмийн 12.2.3 дугаар зүйлд заасан шаардлагыг мөрдөнө.

2.17 Эрүүл мэндийн ажилтан

2.17.1 Эрүүл мэндийн ажилтан нь тэмцээний турш тамирчдын эрүүл мэндтэй холбоотой бүх асуудлыг хариуцах бөгөөд энэ дүрмийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхий шүүгчид ажлаа тайлагнана.

2.17.2 Эрүүл мэндийн ажилтан нь Аюулгүй байдлын ажилтантай хамтран тухайн нөхцөл байдал тэмцээн зохион байгуулахад тохиромжгүй гэж үзвэл Ерөнхий шүүгчид зөвлөмж өгч, шаардлагатай бол замын өөрчлөлт эсвэл тэмцээний зохион байгуулалтын арга хэлбэрийг өөрчлөх санал гаргана.

2.18 Зам хариуцсан ажилтан

2.18.1. Зам хариуцсан ажилтан нь тэмцээний замыг зөв хэмжилт, зураглалын дагуу тогтоох ажлыг зохион байгуулагч байгууллагын өмнө хариуцна.

2.18.2. Зам хариуцсан ажилтан нь:

- Гарааны бүс
- Барианы бүс
- Тэмцээний тоног төхөөрөмж зэргийг зөв байрлуулсан, бүрэн ажиллах боломжтой эсэхийг баталгаажуулна.

2.18.3. Зам хариуцсан ажилтан нь тэмцээн эхлэхээс өмнө:

- Бүх эргэлтийн цэгүүд
- Замын чиглэл өөрчлөх тэмдэглэгээ зөв байрласан эсэхийг шалгаж, Эргэлтийн шүүгчид байрлалдаа ажиллаж байгааг баталгаажуулан Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

2.18.4 Зам хариуцсан ажилтан нь Шүүгч болон Аюулгүй байдлын ажилтантай хамтран тэмцээн эхлэхээс өмнө зам болон тэмдэглэгээг шалгана.

2.19 Бүртгэлийн ажилтан

2.19.1. Тэмцээний бүртгэлийн ажилтан нь дараах шаардлагуудыг шалгаж баталгаажуулна.

- Тамирчин бүр тэмцээний дугаараар зөв танигдсан байх
- Гар, хөлийн хумс авсан байх
- Цаг, үнэт эдлэл болон бусад гоёл чимэглэл зүүгээгүй байх

2.19.2. Тэмцээний бүртгэлийн ажилтан нь эхний дуудлагын бүсэд (first call room) тамирчдын мэдүүлсэн бүх зүүдэг төхөөрөмж (wearables)-ийг бүртгэж, зөвхөн Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны Задгай усанд сэлэлтийн тэмцээнд ашиглахыг зөвшөөрсөн төхөөрөмжүүдийг ашиглаж байгаа эсэхийг баталгаажуулна.

2.19.3. Тэмцээний бүртгэлийн ажилтан нь тэмцээн эхлэхээс өмнө бүх тамирчид цугларах бүсэд заасан цагт ирсэн эсэхийг шалгана.

2.19.4. Тэмцээний бүртгэлийн ажилтан нь гарааны танилцуулга эхлэхээс өмнө бүх тамирчид цугларах бүсэд ирсэн эсэхийг бүртгэж, энэ талаар Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

2.19.5. Тэмцээний бүртгэлийн ажилтан нь энэхүү дүрмийн 3.2.1-д заасны дагуу тэмцээн эхлэхэд үлдсэн хугацааны талаар тамирчид болон техникийн албан тушаалтнуудад мэдээлж байна.

2.19.6. Тэмцээний бүртгэлийн ажилтан нь гарааны бүсэд үлдээсэн тамирчдын хувцас, хэрэгслийг барианы бүс рүү аюулгүй тээвэрлэж, барианд тамирчдыг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.19.7. Тэмцээний бүртгэлийн ажилтан нь барианы дараа уснаас гарч буй тамирчинд дэмжих багийн гишүүн байхгүй бол, түүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай наад захын тоног төхөөрөмж, үйлчилгээг бэлэн байлгахад анхаарна.

2.19.8. Тэмцээний бүртгэлийн ажилтан нь тэмцээнээс гарсан эсвэл замаа дуусгаагүй (DNF) тамирчдын талаар Ерөнхий шүүгч болон Нарийн бичиг шүүгчид мэдээлнэ.

2.20 Нарийн бичиг шүүгч (Recorder)

2.20.1. Нарийн бичиг шүүгч нь дараах үүргийг гүйцэтгэнэ.

- Тэмцээнээс гарсан тамирчдыг бүртгэх
- Тэмцээний явцад бүртгэгдсэн бүх дүрмийн зөрчлийг тэмдэглэх
- Албан ёсны маягтанд тэмцээний үр дүнг бүртгэх
- Багийн шагналтай холбоотой холбогдох бүртгэлийг хөтлөх

2.21. Видео хяналтын шүүгч

2.21.1 Хэрэв Видео туслах шүүлтийн систем (Video Assistant Referee) ашиглаж байгаа бол Видео хяналтын шүүгчийг томилно.

2.21.2 Видео туслах шүүлтийн системийг Ерөнхий шүүгчид тэмцээний дүрмийн зөрчлийг тогтоож шийдвэр гаргахад туслах зорилгоор ашиглана.

2.21.3 3 км хасагдах спринт төрөлд Видео хяналтын шүүгч нь дүрмийн зөрчлийг видео системээр ажиглаж, бүртгэн Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

2.21.4 Видео хяналтын шүүгч нь тамирчид барианы бүсэд (finish funnel) орсноос эхлэн барианы хавтанд хүрэх хүртэл бүх бариаг хянаж, дүрмийн зөрчлийг бүртгэн Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

(Энэ нь энэхүү дүрмийн 5 дугаар зүйл болон 12.1.3 дугаар зүйлд заасны дагуу хийгдэнэ.)

2.21.5 Видео хяналтын шүүгч барианы бүсэд тамирчин дүрэм зөрчснийг тогтоовол тухайн тамирчин тэмцээнээс хасагдана.

2.21.6 Тэмцээн дууссаны дараа Ерөнхий шүүгч нь Видео хяналтын шүүгчийн мэдээлсэн бүх зөрчлийг шалгаж, эцсийн шийдвэр гаргана.

ГУРАВ. ГАРАА

3.1. Гарааны байгууламж

3.1.1 Задгай усанд сэлэлтийн тэмцээнийг зохион байгуулагч байгууллага/зохион байгуулах хороо нь:

- Суурин гарааны тавцангаас эсвэл
- Уснаас гараа эхлэх эсэхийг шийдвэрлэнэ.

Хэрэв тамирчид уснаас гараа авах бол ус нь энэхүү дүрмийн 12.2.2-д заасан шаардлагын дагуу хангалттай гүнтэй байх ёстой.

3.1.2 Хэрэв гараа гарааны тавцангаас эхлэх бол Ерөнхий шүүгч (эсвэл шүүгч) тамирчдын байрлалыг сугалаагаар тогтооно.

3.1.3 Хэрэв гараа уснаас эхлэх бол гарааны шугамыг усны гадаргуу дээр байрлуулсан тусгай төхөөрөмж эсвэл тэмдэглэгээгээр тодорхой заана.

3.2. Тэмцээн эхлэхийн өмнөх ажиллагаа

3.2.1. Тэмцээн эхлэхээс өмнө Бүртгэлийн ажилтан нь тодорхой хугацааны давтамжтайгаар, сүүлийн 5 минутад минут тутамд тамирчид болон техникийн албан тушаалтнуудад гарааны танилцуулга эхлэх хүртэл үлдсэн хугацааг мэдээлнэ.

3.2.2. Тэмцээн эхлэхийн өмнө богино хэмжээний тэмцээний өмнөх танилцуулга (pre-race briefing) зохион байгуулагдах бөгөөд тухайн уралдаанд оролцож буй бүх тамирчин заавал оролцоно.

3.2.2.1 Энэхүү дүрмийн 3.2.2-т заасан тэмцээний өмнөх танилцуулгад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй тамирчныг Ерөнхий шүүгчийн шийдвэрээр:

- Тэмцээнээс хасах, эсвэл
- Торгуулийн арга хэмжээ авах боломжтой.

3.2.2.2 Хэрэв тамирчин хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцорч танилцуулгад оролцсон бол Ерөнхий шүүгчийн шийдвэрээр шар картаар торгоно.

3.2.3 Тамирчид тэмцээн эхлэхээс өмнө зохион байгуулагчдын тогтоосон цагт дуудлагын өрөөнд (final call room)-д өөрсдийн албан ёсны тэмцээний мандат (accreditation)-ын хамт ирж бүртгүүлнэ.

3.2.3.1 Хэрэв тамирчин энэхүү дүрмийн 3.2.3-т заасан шаардлагыг биелүүлэхгүй бол Ерөнхий шүүгчийн шийдвэрээр тухайн тамирчныг тэмцээнээс хасаж, уралдаанд оролцуулахгүй.

3.2.4 Эрэгтэй болон эмэгтэй уралдаануудыг тус тусад нь эхлүүлнэ. Гэвч:

3.2.4.1 Хэрэв тэмцээний зарласан хөтөлбөр, цагийн хуваарьт өөрчлөлт оруулах шаардлага гарвал дараах мэдээлэлд үндэслэн Зохион байгуулах хороо шийдвэр гаргаж болно. Үүнд:

- Оролцогчдын тоо
- Эрүүл мэндийн ажилтан болон Аюулгүй байдлын ажилтны тайлан
- Зохион байгуулах хорооны танилцуулсан бусад холбогдох мэдээлэл

Эдгээрт үндэслэн уралдааны эхлэх дараалал болон цагийн хуваарийг тогтооно.

3.2.4.2 Хэрэв нэгэн зэрэг хэд хэдэн уралдаан зохион байгуулахаар шийдвэрлэвэл уралдаан бүрт тусдаа Ерөнхий шүүгч томилогдох бөгөөд албан ёсны дүн, байр эзлэлт нь тусдаа уралдаан гэж тооцогдоно.

3.2.4.3 Тухайн уралдаанд томилогдсон Ерөнхий шүүгч нь дараах байгууллагуудын зөвлөмжийг харгалзан:

- Эрүүл мэндийн болон Аюулгүй байдлын ажилтнууд
- Зохион байгуулах хороо (LOC)

уралдааны эхлэх цаг болон дарааллыг (хүйс, насны ангилал гэх мэт) тогтооно.

3.2.5 Зохион байгуулагч урьдчилан өөрөөр тогтоогоогүй бол Ерөнхий шүүгч оролцогчдын тоонд үндэслэн:

- Эрэгтэй болон эмэгтэй уралдааныг хамт эхлүүлэх, эсвэл
- Тус тусад нь эхлүүлэх шийдвэр гаргана.

Гэвч уралдаан хамт эхэлсэн тохиолдолд ч албан ёсны дүн, байр эзлэлт нь тусдаа уралдаан гэж тооцогдоно.

3.3 Тэмцээний гараа

3.3.1 Ерөнхий шүүгч гараа эхлэх гэж байгааг ногоон тугийг дээш өргөж, шүглээр хэд хэдэн богино дохио өгч мэдэгдэнэ.

3.3.2 Ерөнхий шүүгч гарааг гарааны шүүгчийн (Starter) удирдлагад шилжүүлж байгааг илэрхийлж тугийг гарааны шүүгч рүү чиглүүлнэ.

3.3.3 Гарааны шүүгч нь бүх тамирчинд тодорхой харагдах байрлалд байрлана.

3.3.4 Гарааны шүүгчийн “Take your marks” (Байрлалдаа) гэсэн дохиогоор бүх тамирчин даруй:

- Хэрэв гарааны тавцан ашиглаж байгаа бол нэг хөлөө тавцангийн урд ирмэгт хүргэж,
- Хэрэв гарааны тавцан ашиглахгүй бол гарааны шугамын дагуу гарааны байрлалд орно.

3.3.4.1 Хэрэв тамирчин Ерөнхий шүүгч эсвэл гарааны шүүгчийн зааврыг (үүнд 3.3.4-т заасан шаардлага багтана) биелүүлээгүй гэж Ерөнхий шүүгч үзвэл тухайн

тамирчныг шар картаар торгож бүртгэлд тэмдэглэнэ. (Дүрмийн 4.2.1.1-д заасан журмын дагуу явагдана)

3.3.5 Бүх тамирчин бэлэн болсон гэж гарааны шүүгч үзвэл гарааны дохиог өгнө. Гарааны дохио нь:

- Дууны
- Харааны аль аль хэлбэртэй байх бөгөөд цагаан туг ашиглана.

3.3.5.1 Хэрэв Ерөнхий шүүгч уралдааны гараа бүх тамирчдад шударга бус болсон гэж үзвэл уралдааныг дахин эхлүүлэх шийдвэр гаргаж болно.

Ийм тохиолдолд бүх тамирчдыг:

- Гарааны шугамын ард, эсвэл
- Гарааны тавцан дээр буцаан байрлуулж, дүрмийн 3.3 дугаар зүйлд заасны дагуу дахин гарааг эхлүүлнэ.

3.4. Гарааны шударга бус давуу тал

Хэрэв Ерөнхий шүүгч тамирчин гарааны үед шударга бусаар давуу тал олж авсан гэж үзвэл тухайн тамирчныг 4.2 дугаар зүйлд заасны дагуу:

- Шар тугаар торгох эсвэл
- Улаан тугаар торгож тэмцээнээс хасна.

3.5. Усан дээрх дагалдах завь

Тэмцээн эхлэхээс өмнө дагалдах завь (Escort Craft) болон аюулгүй байдлын завь (Safety Craft) нь тамирчдын хөдөлгөөнд саад болохооргүй байрлалд байрлана. Хэрэв тамирчныг завинд авах шаардлага гарвал завь:

- Тамирчны ар талаас, эсвэл
- Хажуугаас ойртоно.

Завь нь:

- Тамирчдын дундуур явах
- Тамирчдын хөдөлгөөнд саад учруулах зэргийг хатуу хориглоно.

Хэрэв эмнэлгийн шалтгаанаар хөндлөнгөөс оролцох шаардлага гарвал энэ ажиллагааг Аюулгүй байдлын завь гүйцэтгэнэ.

ДӨРӨВ.ТЭМЦЭЭН

4.1. Тэмцээний явц

4.1.1 Бүх задгай усанд сэлэлтийн тэмцээнүүд нь чөлөөт (Freestyle) сэлэлтээр зохион байгуулагдана.

4.1.2 Тамирчин дараах журмыг баримтална:

- Уралдааны замыг даган сэлэх,
- Бүх эргэлтийн тууз (turn buoy)-ыг зөв дарааллаар, зөв чиглэлд тойрох,
- Замын заагийг хэтрүүлэхгүй байх,
- Замыг бүрэн дуусгах,
- Бусад тамирчдад шударга бус давуу тал авах зорилгоор саад хийхгүй байх,
- Шүүгчдийн зааврыг дагах.

4.1.2.1.Энэхүү зүйлд заасан “замын зааг” гэдэгт:

- Замын гаднах хязгаар,
- Аюулгүй байдлын хязгаар,
- Хэрэв ашиглаж байгаа бол дундын хаалга буюу зууван хаалга (Intermediate Gate),
- Тэмцээний төгсгөлд байрлах барианы хавтан орно.

4.1.2.2 Хэрэв тамирчин ямар нэг эргэлтийн тууз эсвэл зууван хаалгыг алдаж орхивол, дараах нөхцлүүд бүрэн хангагдсан тохиолдолд зөв замд эргэж сэлэх боломжтой:

- Эрсдэлгүй гэж үзсэн тохиолдолд;
- Бусад тамирчдад саад учруулахгүй;
- Дараагийн эргэлтийн тууз хүртэл засвар хийх;
- Алдааны улмаас шударга бус давуу тал олж аваагүй байх.

4.1.3 Уралдааны явцад тамирчин замын дагуу сэлэх ёстой. Алхах, гүйх, үсрэх хориотой.

4.1.4 Тамирчин уралдааны явцад ямар нэг тогтмол эсвэл хөвөх объект, завь, эсвэл завь дээрх хүнээс зориуд дэмжлэг авах хориотой. Харин тамирчин сэтгэл санааны болон бие махбодын эрсдэлд орсон үед эмнэлгийн багийн ажилтан туслах боломжтой.

4.1.4.1 Хэрэв шүүгч тамирчныг зориудаар дэмжлэг авсан гэж үзвэл Ерөнхий шүүгчид шууд мэдээлнэ. Ерөнхий шүүгчийн шийдвэрээр тухайн тамирчныг тэмцээнээс хасах боломжтой.

4.1.5 Тамирчин уралдаанд оролцоогүй хүний тусламжтайгаар (pacing) хэмнэл авах хориотой. Энэ зөрчил гарвал Ерөнхий шүүгч эсвэл тухайн зөрчлийг харсан шүүгч улаан тугаар торгож тэмцээнээс хасна.

4.1.6 Тамирчинд ямар нэг усан дээрх завиар зориудаар хэмнэл өгөх, дамжуулан хурд өгөх хориотой.

4.1.7 Эргэлтийн шүүгчид тамирчныг шударга бус давуу тал авч байна гэж үзвэл завьнаас зай барихыг зөвлөж, зааварлана.

4.1.7.1 Ерөнхий шүүгч нь тухайн тамирчинд аль нэг тэмцээний шүүгч өмнө нь зай барих талаар заавар өгсөн боловч тухайн тамирчин энэ хэсгийн 4.1.6 эсвэл 4.1.7 дугаар зүйлүүдийг үргэлжлүүлэн зөрчсөн гэж үзвэл, энэ хэсгийн 4.2.1.1-д заасны дагуу тухайн тамирчныг шар тугаар торгоно.

4.1.8 Тамирчин уралдааны эхэнд хоёр микрочип дамжуулагчийг зүүн болон баруун бугуйндаа зүүх ёстой.

- Хэрэв тэмцээний явцад дамжуулагч унасан эсвэл бугуйнаас хөндийрсөн бол Эргэлтийн шүүгч эсвэл шүүгч нь Ерөнхий шүүгчид мэдээлнэ.
- Ерөнхий шүүгчийн заавраар усан дээрх ажилтан солих микрочипийг олгоно.
- Тамирчид зөвхөн хоёр микро дамжуулагчаа хоёуланг нь алдсан тохиолдолд микрочип авах шаардлагатай.

4.1.9 Тамирчин барианд орох үедээ дор хаяж нэг микрочиттэй байх шаардлагатай бөгөөд хэрэв тамирчин нэг ч микрочипгүй тэмцээн дуусгавал тэмцээнээс хасагдана.

4.2. Ёс зүйн зөрчил

4.2.1 Амаар болон биеийн хэлэмжээр анхааруулах

4.2.1.1 Шаардлагатай гэж үзвэл Шүүгч нь тамирчин болон түүний туслах багийн гишүүдэд усан дээр эсвэл уснаас гадна анхааруулга өгөх боломжтой.

4.2.1.2 Шүүгч нь аман болон биеийн хэлэмжээр анхааруулгыг өгнө. Бүх анхааруулгыг бүртгэж, шаардлагатай бол Ерөнхий шүүгчид мэдэгдэнэ.

4.2.2 Шар карт, улаан картаар торгох

4.2.2.1 Ерөнхий шүүгч эсвэл шүүгч нь тэмцээний явцад тамирчин эсвэл түүнийг дэмжих бүрэлдэхүүн (Athlete Support Personnel) нь Тэмцээний дүрмийн нэг (1) буюу

түүнээс дээш заалтыг зөрчсөн гэж үзсэн тохиолдолд, тамирчинд шар карт эсвэл улаан картаар торгоно.

4.2.2.2 Хэрэв Видео туслах шүүгч (Video Assistant Referee) систем ашиглагдаж байгаа тохиолдолд, Видео хяналтын шүүгч (Video Review Judge) тухайн зөрчлийг биечлэн харсан бол Ерөнхий шүүгчид мэдээлнэ.

4.2.2.3. Хэрэв тамирчин тэмцээний явцад дүрэм зөрчиж эхний шар картын торгууль авах нөхцөл үүсвэл, Ерөнхий шүүгч эсвэл шүүгч боломжтой үед шар туг өргөж, тухайн тамирчны дугаарыг бичсэн картыг үзүүлэн анхны зөрчлийг мэдэгдэнэ. Тухайн зөрчлийг бүртгэж, бүх шүүгчдэд мэдэгдэнэ.

4.2.2.4 Анхны шар карт нь тамирчны албан ёсны анхааруулга бөгөөд, тухайн тамирчин тэмцээний журмын тодорхой заалтыг зөрчсөн болохыг илтгэнэ.

4.2.2.5 Хэрэв тамирчин уралдааны явцад хоёр дахь удаагаа зөрчил гаргавал, Ерөнхий шүүгч эсвэл шүүгч боломжтой үед улаан туг өргөж, тамирчны дугаарыг бичсэн карт харуулна.

- Тамирчныг яаралтай тэмцээнээс хасна, эсвэл Ерөнхий шүүгчийн шийдвэрээр тэмцээний төгсгөлд хасах боломжтой (4.2.2.5 зүйлтэй нийцүүлнэ). Тухайн зөрчлийг бүртгэж, бүх шүүгчдэд мэдэгдэнэ.

4.2.2.6 Хэрэв Ерөнхий шүүгч эсвэл шүүгч тамирчин, эсвэл түүний туслах завь, туслах багийнхан усан дахь бусад тамирчдад саад учруулсан, шударга бус үйлдэл хийсэн гэж үзвэл, тамирчныг тэмцээнээс шууд хасна. Улаан туг өргөж, тамирчны дугаарыг харуулна. Тухайн зөрчлийг бүртгэж, бүх шүүгчдэд мэдэгдэнэ.

4.2.2.7. 4.2.2.5 болон 4.2.2.6 зүйлд заасан зөрчлөөр хасагдсан тамирчин шууд уснаас гарч, уралдаанд оролцох эрхгүй болно. Ерөнхий шүүгч эсвэл шүүгч 2 гараа биеийнхээ урд солбилцуулан дохио өгч, тамирчин уралдаанаа үргэлжлүүлэх боломжгүй болсныг мэдэгдэнэ.

4.2.3. Энэхүү дүрмийн Хавсралт 7 нь зөрчлийн төрөл, тэдгээрт холбогдох шар карт, улаан картын ангиллыг харуулсан болно. Ерөнхий шүүгч эсвэл шүүгчийн шийдвэрээр Хавсралт 7-д байхгүй зөрчилд ч арга хэмжээ авч болно.

4.2.4. Спортын бус үйлдэл (Unsporting Conduct) гэж тэмцээнд зохимжгүй, ёс зүйд нийцээгүй үйлдлийг хэлнэ. Үүнд:

- Тэмцээний үе болон тэмцээний бус үед тамирчин, туслах завь, туслах багийн гишүүдийн ямар нэг зорилготой, бие махбодын хүч хэрэглэсэн үйлдэл;

- Тамирчин уралдааны явцад бусад тамирчныг түлхэх, татах, барих;
- Тамирчин бусад тамирчныг замын тууз, тэмдэгтэд шахах зорилготой үйлдэл хийх;
- Тамирчин бусад тамирчны барианд хүрэх үйлдлийг саатуулах.

4.3. Дагалдах завь (Escort craft)

4.3.1. Дагалдах завинд:

- Нэг (1) Эргэлтийн шүүгч (Race Judge),
- Нэг (1) Тамирчны туслах багийн ажилтан,
- Завийг аюулгүй жолоодох багийн бүрэлдэхүүн байрлана.

4.3.2. Дагалдах завь нь тамирчны урд талаас чиглэсэн хөдөлгөөн хийх, шударга бус давуу тал олгох буюу хэмнэл өгөх, хурд дамжуулах үйлдэл (pacing/slip streaming) хийхийг хориглоно.

4.3.3 Дагалдах завь нь тамирчныг завины дунд хэсэгт, эсвэл дундаас урагш байрлалд байлгахын тулд аль болох тогтмол байрлалаа хадгалахыг хичээх ёстой.

4.3.4 Дагалдах завинд тамирчны тэмцээний дугаар болон гишүүн клубын таних тэмдгийг аль ч талаасаа тод харагдахуйц байрлуулна.

4.4. Уралдааны үеийн хоол тэжээл (feeding)

4.4.1 Тамирчин хоол тэжээлийг тэжээлийн тавцан эсвэл туслах завинаас авахдаа байгальд ээлтэй өөрөө задрах саванд, гараар эсвэл хооллох савааны тусламжтай авах ёстой.

4.4.2 Тамирчид уралдааны үеэр гел болон бусад савласан хоол хүнсийг авч явах хориотой. Үүнд сэлэлтийн хувцас доторх зүйлсийг ч оруулан тооцно.

4.4.3 Тамирчин тэжээлийн тавцан эсвэл завинаас шидсэн хоол хүнс эсвэл бусад объект авах хориотой.

4.4.4 Хооллох саваа (Feeding Pole)

- Хэрэв хооллох саваа ашиглаж байгаа бол урт нь 5 метрээс хэтрэхгүй байх ёстой.
- Хооллох саваанд утас, оосор, бусад зүйлс өлгөх хориотой, зөвхөн нэг (1) улс/клубын далбаа л байрлуулах боломжтой.
- Далбаа 30 см × 20 см-аас томгүй, хатуу ирмэггүй даавуун материалтай байх ба ямар ч жин, нэмэлт зүйлгүй байх.

4.4.5 Урьдчилсан бүртгэлд зөвшөөрөгдөөгүй хооллох савааг ашиглах хориотой. Тамирчны туслах бүрэлдэхүүн зөвшөөрөгдөөгүй хооллох саваа ашиглавал тамирчныг тэмцээнээс хасна.

4.4.6 Дагалдах завь болон тэжээлийн тавцангаас тамирчинд зөвлөгөө, заавар өгөхийг зөвшөөрнө. Гэхдээ шүгэл ашиглах хориглоно.

4.5. Цагийн хязгаар

4.5.1 Уралдааны цагийн хязгаарыг дараах байдлаар тооцно:

Эхний байрт орсон тамирчны барианы цагийг үндэслэн, үлдсэн тамирчдад нийт зайны 5 км тутамд (эсвэл түүний хэсэгт) 10 минут нэмж олгоно. Гэхдээ энэ нэмэлт хугацаа хамгийн ихдээ 60 минутаас хэтрэхгүй байна.

4.5.2 Хугацаандаа багтаж дуусгаагүй тамирчныг OTL (цаг хэтэрсэн) гэж тэмдэглэн уснаас гаргана. Ерөнхий шүүгч зөвшөөрвөл уралдааныг дуусгах боломжтой боловч хугацаа хэтэрсэн тамирчин оноо, байр, шагнал авах эрхгүй.

4.6. Уралдааныг онцгой нөхцөлд зогсоох

4.6.1 Ерөнхий шүүгч нь онцгой нөхцөл байдал үүссэн гэж үзвэл Аюулгүй ажиллагааны төлөвлөгөө болон дүрмийн 12.2.3–12.2.3.6 заалтуудыг үндэслэн уралдааныг зогсоох зохицуулалт хийж болно.

4.6.2 Хэрэв 10 км буюу түүнээс бага зайн уралдааны үеэр онцгой нөхцөл байдлын улмаас тэмцээнийг зогсоох (emergency abandonment) тохиолдолд, тэмцээнийг хамгийн ойрын боломжит цагт эхнээс нь дахин явуулна. Хэрэв онцгой нөхцөл байдлын улмаас зогсоохоос өмнө нэг (1) буюу түүнээс олон тамирчин барианд орсон бол, аль хэдийн барианд орсон тамирчдыг харгалзан Ерөнхий шүүгчийн гаргасан шийдвэрийн дагуу эцсийн үр дүнг тогтооно.

4.6.3 Хэрэв 10 км-ээс урт зайн уралдааны үеэр онцгой нөхцөл байдлын улмаас тэмцээнийг зогсоох (emergency abandonment) тохиолдолд: Уралдаан эхлээд хоёроос бага цаг болсон бол тэмцээнийг хамгийн ойрын боломжит үед эхнээс нь дахин явуулна. Харин уралдаан эхлээд хоёроос дээш цаг нь өнгөрсөн бол эцсийн үр дүнг Ерөнхий шүүгчийн шийдвэрээр тогтооно.

ТАВ. ТЭМЦЭЭНИЙ БАРИА

5.1. Аюулгүй байдал эсвэл үйл ажиллагааны шаардлагаас бусад тохиолдолд ямар ч усан дээрх завь (On-water Craft) барианы зурваст (Finish funnel) орж болохгүй.

5.2. Барианы шүүгчид болон цагчин шүүгчид бариаг бүх үед ажиглаж чадах байрлалд байх ёстой. Тэдний байрлах бүс нь зөвхөн тэдэнд зориулагдсан байх ёстой.

5.3 Хэрэв барианы самбар (finish plate) ашиглаж байвал, тамирчин заавал самбарт хүрэх ёстой. Хүрэхгүй бол тэмцээнээс хасна.

5.4 Хэрэв барианы самбар ашиглагдаагүй бол, тамирчин бүр барианы шугмыг өнгөрч сэлж дуусгах ёстой. Тамирчдын байрыг барианы шугамыг хамгийн эхлээд давсан биеийн хэсэгт үндэслэн авсан цагийг баримтлан тогтоогдоно.

5.5. Тамирчин барианы зурвас дотор ямар нэгэн дүрмийн зөрчил гаргавал, Ерөнхий шүүгч тэмцээнээс хасах шийдвэр гаргаж болно.

5.6. Хэрэв тамирчин барианы зурвас дотор дүрэм зөрчвөл, Ерөнхий шүүгч нь видео хяналтын шүүгчтэй хамтран, дүрмийн 2.21.4 дугаар зүйлд заасны дагуу тэмцээнээс хасах шийдвэрийг гаргана.

5.7. Ерөнхий шүүгч эцсийн байрлалыг дараах байдлаар тогтооно:

Автомат шүүлтийн төхөөрөмж (Automatic Officiating Equipment)-ийн бүртгэсэн үр дүнгийн үндсэн дээр, эсвэл Барианы шүүгчийн бүртгэсэн байрлал болон (хэрэв ашиглагдаж байвал) барианы видео бичлэгийн мэдээллийн дагуу, дүрмийн 12.4 дэх заалтыг баримтлан тогтооно.

5.8. Тэмцээний дараах үнэлгээ ба тусламж:

5.8.1 Дагалдах завинд байгаа тамирчны дэмжих бүрэлдэхүүн тамирчин нь уснаас гарч ирэх үед түүнтэй уулзах боломжтой байлгахыг зохион байгуулагчид эрмэлзэнэ.

5.8.2 Зарим тамирчинд уснаас гарах үед эсвэл уснаас гарсны дараа тусламж шаардлагатай байж болно. Гэхдээ шүүгчид, тамирчид, тамирчны дэмжих бүрэлдэхүүн болон бусад хүмүүс тамирчныг маш тодорхой тусламж хүссэн тохиолдолд л туслах ёстой. Тамирчид тусламж хүсэхгүй бол, шүүгчид түүнд хүрч барих хориотой.

5.8.3 Тамирчин уснаас гарах үед тэмцээний эрүүл мэндийн багийн нэг гишүүн түүнийг шалгаж, үнэлгээ хийх ёстой. Үнэлгээ хийх үеэр тамирчин суух боломжтой сандал гаргаж

өгөх шаардлагатай. Эрүүл мэндийн үзлэг дууссаны дараа тамирчны биеийн байдлыг хэвийн гэж үзсэн тохиолдолд, тэмцээний мандатыг буцаан өгнө.

ЗУРГАА. ХОЛИМОГ БАГИЙН ТӨРӨЛ (MIXED TEAM EVENT)

6.1. Ерөнхий зарчим:

6.1.2. Багт дөрвөн тамирчин: хоёр (2) эрэгтэй, хоёр (2) эмэгтэй.

6.1.2. Бүх гишүүд нэг багийн харьяалалтай байна.

6.1.3 Бүх багийн анхны тамирчид зэрэг эхэлнэ.

6.1.3.1 Тавцангаас эхлэх бол байрлал санамсаргүй байдлаар тогтоогдоно.

6.1.3.2 Усан дотроос эхлэх бол энэхүү дүрмийн 3.1.3 заалтын дагуу эхэлнэ.

6.1.4 Багийн гишүүн тус бүр нийт замын 4/1 хэсэгтэй тэнцэх замыг сэлнэ.

6.1.5 Уралдааныг энэхүү дүрмийн 3–5 хэсэгт заасны дагуу явуулна.

6.1.6 Багийн гишүүд дараалан буухиаг үргэлжлүүлэх ба заавал урьдчилан мэдэгдсэн дарааллын дагуу гараандаа гарч сэлэх шаардлагатай.

6.1.6.1 Дарааллын дагуу гараандаа гараагүй бол баг хасагдана.

6.1.7. Гарааг шилжүүлэх (Changeovers):

6.1.7.1 Тэмцээнд гараа шилжүүлэх тавцан ашиглана.

6.1.7.2 Гараа шилжүүлэх бүсэд гарааг шилжүүлнэ, урт нь дор хаяж 5 метр.

6.1.7.3 Тамирчин зөвхөн солилт хийх үед бүсэд орох бөгөөд бусад тамирчдад саад болохгүй байх ёстой.

6.1.7.4. Гараа шилжүүлэх тавцан ашиглах:

6.1.7.4.1. Усанд байгаа тамирчин тавцанд хүрэх хүртэл дараагийн тамирчны хоёр хөл тавцангаас салаагүй байна.

6.1.7.4.2. Усанд байгаа тамирчин тавцанд хүрэхэд дараагийн тамирчин тавцан дээрээс ус руу үсэрнэ.

6.1.7.5. Гараа шилжүүлэх тавцан ашиглах боломжгүй бол:

6.1.7.5.1. Гараа шилжүүлэлт хоёр тамирчин хоёулаа усанд байгаа үед явагдана. Багийн сэлж байгаа тамирчин усан доторх солилтын бүсэд ойртох үед дараагийн ээлжинд сэлэх тамирчин усанд орно.

6.1.7.5.2. Багийн сэлж байгаа тамирчин дараагийн тамирчинтайгаа хүрэлцэх хүртэл, дараагийн тамирчны дор хаяж нэг гар тавцанд хүрсэн байх ёстой.

6.1.7.5.3. Буухиаг шилжүүлэх үед багийн хоёр тамирчны гар эсвэл шууны хүрэлцээ усны мандал дээр явагдах ёстой.

6.1.7.6. Өөрийн сэлэх зайг дуусгасан тамирчин аюулгүй боломж бүрдмэгц, шүүгчийн зааврын дагуу уснаас нэн даруй гарна.

ДОЛОО. ХАСАГДАХ 3 КМ-ИЙН ТӨРӨЛ (дараа нэмэж орууллах)

НАЙМ. НАСНЫ АНГИЛАЛ БА ОРОЛЦОХ ЭРХ

8.1 МУССХ-ны Улсын аварга шалгаруулах тэмцээн болон Насны ангилалтай тэмцээнд оролцохын тулд тамирчин тухайн жилийн 12 сарын 31-ний байдлаар 14 нас хүрсэн байх ёстой.

8.2. Залуучуудын тэмцээнд оролцохын тулд:

8.2.1. 14-15 насны ангилалд: тухайн жилд 12 сарын 31-ний байдлаар 14 эсвэл 15 настай байх.

8.2.2. 16-17 насны ангилалд: тухайн жилд 16 эсвэл 17 настай байх.

8.2.3. 18-19 насны ангилалд: тухайн жилд 18 эсвэл 19 настай байх.

8.3. Гишүүн клубуудын нэрэмжит тэмцээн болон бусад тэмцээний зохион байгуулагчид дээрхитэй ижил болон өөр насны ангиллыг хэрэглэж болно.

ЕС. БҮРТГЭЛ БА ГАРААНЫ МЭДҮҮЛЭГ

9.1 Насанд хүрэгчдийн Задгай усанд сэлэлтийн УАШТ-нд:

- Гишүүн клуб/байгууллага нь хувийн гараатай уралдааны төрөл зай тус бүрт хамгийн ихдээ 4 тамирчин оролцуулах эрхтэй.

9.2 Насанд хүрэгчдийн Задгай усанд сэлэлтийн УАШТ-нд:

- Гишүүн клуб/байгууллага нь зөвхөн нэг (1) баг оролцуулах эрхтэй. Баг нь 2 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчнаас бүрдэх ёстой.

9.3 МУССХ-ны Залуучуудын Задгай усанд сэлэлтийн УАШТ-нд:

- Гишүүн клуб/байгууллага нь хувийн гараатай уралдааны төрөл зай тус бүрт хамгийн ихдээ 4 тамирчин оролцуулах эрхтэй.

9.4: МУССХ-ны Залуучуудын Задгай усанд сэлэлтийн УАШТ-нд

- Гишүүн клуб/байгууллага нь зөвхөн нэг (1) баг оролцуулах эрхтэй.
- Баг нь 2 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчнаас бүрдэх ёстой.
- Тамирчин зөвхөн нэг багийн тэмцээнд оролцож болно.

9.5 МУССХ-ны гишүүн байгууллагуудын зохион байгуулж байгаа тэмцээнд:

- МУССХ-той зөвшилцсний үндсэн дээр зарим хязгаарласан заалтыг мөрдөхгүй байж болно.

АРАВ. УСНЫ ХУВЦАС, ТЕХНОЛОГИ, БУСАД ХЭРЭГСЭЛД

ТАВИГДАХ ШААРДЛАГА

10.1 Усны температур 18.0°C эсвэл түүнээс дээш үед:

- Тамирчин нэг (1) усны хувцас өмсөнө (нэг эсвэл хоёр хэсэг, дулаан хадгалах хувцас (wetsuit) биш, Дүрмийн 10.3 заалтын дагуу).
- Уралдаанд 1 эсвэл 2 малгай өмсөнө.
- Нүдний шил, хамрын хавчуур, чихний бөглөөс хэрэглэж болно.

10.2 Усны температур 18.0°C-оос доош үед:

- Тамирчин дулаан хадгалах хувцас (wetsuit) өмсөнө.
- Уралдаанд 1 эсвэл 2 малгай өмсөнө.
- Нүдний шил өмсөж болно.
- Тамирчин дулаан хадгалах хувцас (wetsuit)-ны дотуур зөвхөн нэг усны хувцас давхарлан өмсөж болно.

10.3. Усны температур 18.0°C–20.0°C хооронд байвал Ерөнхий шүүгч Аюулгүй байдал, Эрүүл мэндийн ажилтны зөвлөмжийн дагуу нөхцөл байдал тамирчдад аюултай гэж үзвэл, бүх тамирчдад дулаан хадгалах хувцас (wetsuit) өмсөхийг шаардаж болно.

10.4. Тамирчин арьсандаа тос, тосон түрхлэг эсвэл түүнтэй төстэй бодис түрхсэн байдалтайгаар тэмцээнд оролцохыг зөвшөөрнө. Гэхдээ тос, тосон түрхлэг эсвэл түүнтэй төстэй бодисын хэмжээ нь Ерөнхий шүүгчийн үзэмжээр хэт их хэмжээтэй гэж тооцогдохооргүй байх ёстой.

10.5. Уралдааны өмнө болон уралдааны турш тамирчин хурууны болон хөлийн хумсаа зассан байх ёстой. Мөн гоёл чимэглэл, цаг зэрэг зүйлсийг зүүж болохгүй.

10.6. Дүрмийн 10 хэсэгт зөвшөөрөгдсөн хувцас, наалт, усны хэрэгслээс өөр ямар нэг хэмнэл өгөх төхөөрөмж, хурд нэмэгдүүлэх хэрэгсэл ашиглаж болохгүй.

10.7. Багийн буухиа тэмцээнд оролцож байгаа тамирчин багийн ижил өнгө, хэв маягийн малгай өмсөнө.

10.8 Технологи

10.8.1 Дрон, GPS хянах төхөөрөмж, био-эмнэлгийн мэдрэгч зэрэг технологи, мөн транспондероор дамжуулан цусны даралт, биеийн температур, сэлэлтийн хэмнэл (stroke rate), амьсгалын давтамж зэрэг физиологийн мэдээлэл бүртгэдэг төхөөрөмжүүдийг ашиглахыг хориглоно. Зөвхөн Дэлхийн усан спортын холбоо (World Aquatics)-ны зөвшөөрсөн буюу тухайн тэмцээний өдөр World Aquatics-ын вэбсайт дээр нийтлэгдсэн Open Water Swimming-д зөвшөөрөгдсөн зүүдэг төхөөрөмжүүдийн жагсаалтад багтсан тохиолдолд ашиглахыг зөвшөөрнө.

10.8.2. Тамирчинд зөвхөн мэдээлэл цуглуулах зорилготой автомат өгөгдөл бүртгэх төхөөрөмж ашиглахыг зөвшөөрнө. Гэхдээ тухайн төхөөрөмж нь: мэдээлэл, дуу чимээ эсвэл дохиог тамирчин руу дамжуулах буюу хүлээн авах боломжгүй байх ёстой. Мөн тамирчны хурд, хөвөх чадвар, эсвэл тэсвэрийг нэмэгдүүлэхэд туслах боломжгүй байна.

10.8.3. Тамирчин ямар нэг технологи эсвэл зүүдэг төхөөрөмж ашиглаж байгаа бол анх бүртгүүлэх үедээ тухайн төхөөрөмжийг заавал мэдүүлэх ёстой. Ашиглаж буй технологи эсвэл зүүдэг төхөөрөмжийг мэдүүлээгүй тохиолдолд тухайн тамирчныг тэмцээнээс хасна.

АРВАН НЭГ. ТЭМЦЭЭНИЙ ҮЕЭР ТАМИРЧДЫГ ТАНИХ ТЭМДЭГЛЭГЭЭ

11.1. Тамирчин бүр өөрийн дугаарыг дараах байдлаар байрлуулна:

11.1.1 Нурууны дээд хэсэг буюу далан дээр. Мөн хоёр мөрний дээр хэвтээ байрлалтайгаар, дугаар бүр 100 мм өндөр, 60 мм өргөн байна.

11.1.2 Гарын шууны хэсэг дээр босоо байрлалтайгаар, дугаар бүр 100 мм өндөр, 60 мм өргөн байна.

11.1.3 Гарын алганд, бугуйн доод хэсэг рүү чиглэсэн хэвтээ байрлалтайгаар, тоон цифрээр бичнэ.

11.1.4 Тоон дугаар нь маш бараан (жишээ нь хар) эсвэл маш цайвар (жишээ нь цагаан) өнгөтэй байх бөгөөд дугаарыг бичиж буй суурь (жишээ нь wetsuit, арьсны өнгө)-тай ялгарахуйц байх ёстой. Ингэснээр шүүгчид амархан харах боломжтой байна. Тамирчны гар болон бүх бие, дулаан хадгалах хувцас (wetsuit) дээр дугаарыг маркер үзгээр бичихийг зөвшөөрнө.

АРВАН ХОЁР. ЗАДГАЙ УСАНД СЭЛЭЛТИЙН БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

12.1 Задгай усанд сэлэлтийн тэмцээнд дараах байгууламж шаардлагатай:

12.1.1 Гарааны тавцан, тэжээлийн тавцан, буухиа солилцооны тавцан, эргэлтийн хөвөгч тэмдэг (буй), мөн эргэлтийн шүүгчийн завь буюу тавцан нь найдвартай бэхлэгдсэн байх бөгөөд түрлэг, салхи болон бусад нөлөөллөөс шалтгаалан хөдөлгөөнд орох ёсгүй.

12.1.2 Гарааны тавцан:

12.1.2.1 МУССХ-ны бүх тэмцээнүүдэд, МУССХ-той урьдчилан өөрөөр тохиролцоогүй бол гарааны тавцангийн урт нь дараах томъёогоор тооцсон урттай байх ба үүнээс илүү урт байж болно.

(тамирчдын тоо × 60 см) + гарааны тавцангийн хоёр тал тус бүрт тав (5) метр.

12.1.2.2 Гарааны тавцан дээр тамирчдын гарааны байрлалуудыг 60 см өргөнөөр тэмдэглэсэн байх бөгөөд байрлал бүрийг өсөх дарааллаар дугаарлана. №1 дугаар нь гарааны тавцан руу орох хэсгээс хамгийн хол байрлах гарааны байрлалд байрлана (эсвэл гарааны тавцан руу орох хэсгээс адил зайтай хоёр байрлал байгаа тохиолдолд №1 байрлалыг аль талаас нь эхлэн дугаарлахыг Техникийн зөвөлгөөн / Багийн ахлагчдын хурал дээр тогтооно).

12.1.2.3 Гарааны тавцан нь гарааны өмнөх шаардлагатай үйл ажиллагааг явуулахад хангалттай өргөнтэй байх бөгөөд гарааны үед тамирчид болон техникийн албан хаагчдын жинг даахуйц хийц, бүтцээр хийгдсэн байна.

12.1.3 Бариа:

12.1.3.1 Бариад ойртох үед замын хил хязгаарыг илэрхийлэх тод өнгийн тэмдэглэгээгээр тодорхой заасан байна.

12.1.3.2 Барианы төхөөрөмж рүү хүрэх хэсгийг барианы хананд ойртох тусам нарийсах байдлаар байрлуулсан хэвтээ тэмдэглэгээгээр тодорхой тэмдэглэсэн байна.

12.1.3.3 Барианы төхөөрөмж нь тодорхой заагдсан босоо гадаргуутай барианы хавтан байна. МУССХ-ний тэмцээнүүдэд боломжтой тохиолдолд барианы төхөөрөмж нь босоо байрлалтай, хамгийн багадаа тав (5) метр өргөнтэй барианы хавтан байна. Энэ хавтан нь салхи, түрлэг болон тамирчин барианд хүрэх үед үүсэх хүчний нөлөөгөөр хөдөлгөөнд орохгүйгээр найдвартай бэхлэгдсэн байна. (шаардлагатай бол хөвөгч төхөөрөмжид бэхэлж болно). Барианы хавтангийн доод ирмэг нь усны түвшнээс 500 мм-ээс багагүй, 700 мм-ээс ихгүй өндөрт байрлана. Зохион байгуулах хороо (LOC), Аюулгүй ажиллагааны ажилтан болон Ерөнхий шүүгчтэй хэлэлцэж тохиролцсны үндсэн дээр дээрх хэмжээг бага зэрэг өөрчилж болно.

12.1.3.4 МУССХ-ны тэмцээнүүдэд бариаг барианы хавтангийн хоёр тал, дээрээс нь дахин үзэх боломжтой, удаашруулсан бичлэг (slow motion) болон автомат цагийн төхөөрөмж ашиглахыг эрмэлзэнэ.

12.1.3.5 Хэрэв Видео туслах шүүгч (VAR-Video Assistant Referee) ашиглаж байгаа бол барианы хавтангийн хоёр үзүүрт нэмэлт камерууд байрлуулна. Эдгээр камерууд нь барианы хонгилын (finish funnel) эхлэлээс эхлэн 12.1.3.4-д заасан барианы камерын бичлэг эхлэх цэг хүртэлх хэсгийг тасралтгүй дүрсжүүлж бичих бөгөөд нэмэлт камерын бичлэг нь барианы камерын бичлэгтэй давхардах ёстой (Хавсралт 5-д үзүүлсэн зурагт тайлбарласны дагуу).

12.1.4 Эргэлт болон замын чиглэлийн өөрчлөлт:

12.1.4.1 Замын эргэлт болон чиглэлийн аливаа өөрчлөлтийг тодорхой тэмдэглэсэн байна. Эргэлт болон замын чиглэлийн өөрчлөлтийг заах эргэлтийн хөвөгч тэмдэг нь чиглүүлэх зориулалттай хөвөгч тэмдэгнүүдээс өөр өнгөтэй байна. Боломжтой тохиолдолд гараанаас эхний эргэлтийн хөвөгч тэмдэг хүртэлх зайг аль болох урт байхаар тогтоож, эргэлтийн хэсэгт үүсэх бөөгнөрлийг багасгана.

12.1.4.2 Замын эргэлт болон чиглэлийн өөрчлөлт бүр дээр тодорхой тэмдэглэгдсэн завь эсвэл тавцан дээр Эргэлтийн шүүгч байрлана. Эргэлтийн шүүгч нь тамирчдын эргэлт эсвэл чиглэлийн өөрчлөлтийг харахад саад учруулахгүй байрлалд байрласан байна.

12.1.5 Тэжээл авах тавцан:

12.1.5.1 Тэжээлийн тавцан бүр нь тухайн тавцан болон дээр нь ажиллах багийн гишүүд, техникийн албан хаагчдын аюулгүй ажиллагааг хангахуйц хангалттай хэмжээ, хөвөх чадвартай байна. МУССХ-той урьдчилан өөрөөр тохиролцоогүй бол тэжээл авах тавцангийн урт нь дараах томъёогоор тооцсон хэмжээстэй буюу түүнээс урт байж болно: (тэжээл өгөх багийн гишүүдийн тоо $\times$ 60 см) + тав (5) метр.

Тэжээлийн тавцангийн өргөн нь тамирчдад өгөх тэжээлийг хадгалах болон бэлтгэхэд хангалттай байх ёстой. Бүх тэжээл өгөх багийн гишүүдийг багтаах хангалттай зайтай

(нэг буюу хэд хэдэн тавцан дээр) байх шаардлагатай. Боломжтой тохиолдолд тэжээл өгөх багийн гишүүд болон техникийн албан хаагчид тэжээл авах тавцанд замын гадна талаас нэвтрэхээр зохион байгуулна.

12.2 Усны нөхцөл:

12.2.1 Зохион байгуулагч нь тухайн тэмцээний талбайг ашиглахад тохиромжтой эсэх талаар орон нутгийн холбогдох эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны болон онцгой байдлын албаны дүгнэлтийг авсан байх ёстой. Энэхүү дүгнэлт нь усны цэвэр байдал болон тамирчдын аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй бусад эрсдэлийг хамарсан байна.

12.2.2 Замын аль ч хэсэгт усны гүн нь хамгийн багадаа 1.40 метр байна.

12.2.3 Усны температур нь хамгийн багадаа 16.0°C, хамгийн ихдээ 31.0°C байна.

12.2.3.1 Усны температурыг дараах бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хэмжинэ: Ерөнхий шүүгчийн томилсон шүүгч, Зохион байгуулах хорооны (LOC) төлөөлөгч, мөн Техникийн / Багийн ахлагчдын хурал дээр томилогдсон тэмцээнд оролцож буй багийн нэг төлөөлөгч.

12.2.3.2 Усны температурыг уралдаан эхлэхээс хоёр (2) цагийн өмнө замын гурван цэгт усны гадаргуугаас 40 см-ийн гүнд хэмжинэ. Хэмжсэн гурван температурыг дундажлан усны температурыг тогтооно.

12.2.3.3 Хэрэв усны температур 16.0°C-ээс бага эсвэл 31.0°C-ээс их гарвал Ерөнхий шүүгч нь томилогдсон Аюулгүй ажиллагааны ажилтан болон Эмнэлгийн ажилтантай зөвлөлдөж, усны температурыг дахин хэмжих эсэх, уралдааны гарааг хойшлуулах эсэх, мөн тэмцээнийг түр хойшлуулах эсвэл цуцлах эсэхийг тухайн нөхцөл байдалд үндэслэн шийдвэрлэнэ.

12.2.3.4 Бүх уралдааны үед Аюулгүй ажиллагааны ажилтан нь уралдаан эхлэхээс арван (10) минутын өмнө болон уралдаан эхэлснээс хойш 30 минут тутамд ажлын хэсгийн сонгосон цэгүүдэд усны температурыг хэмжинэ. Бүх хэмжилт болон хэмжсэн байршлуудыг тэмдэглэж, Ерөнхий шүүгч болон Эрүүл мэндийн ажилтанд мэдээлнэ.

12.2.3.5 Хэрэв уралдааны явцад аль нэг хэмжилтийн үед усны температур 16.0°C-ээс бага эсвэл 31.0°C-ээс их гарсан бол Ерөнхий шүүгчийн шийдвэрээр уралдаан үргэлжилж болно. Энэ тохиолдолд 30 минутын дараа температурыг дахин хэмжинэ. Хэрэв усны температур 16.0°C-ээс бага эсвэл 31.0°C-ээс их хэвээр байвал Ерөнхий шүүгч уралдааныг зогсоож, энэхүү дүрмийн 4.6-д заасан журмыг мөрдөнө. Усны температур 16.0°C-ээс 31.0°C-ийн хооронд болсон тохиолдолд л уралдааныг дахин эхлүүлнэ. Уралдааныг дахин эхлүүлэх эсэхийг Ерөнхий шүүгч 12.2.3.3-д заасны дагуу эцэслэн шийдвэрлэнэ.

12.2.3.6 Уралдааныг дахин эхлүүлэхийн өмнө Ерөнхий шүүгч нь мөн энэхүү дүрмийн 4.6-д заасан нөхцлүүд хангагдсан эсэхийг баталгаажуулна.

12.3 МУССХ-ны задгай усанд сэлэлтийн тэмцээнд дараах тоног төхөөрөмжийг ашиглаж болно:

12.3.1 Уралдааны шүүлтийг хэмжих болон завсрын цагийг (split time) гаргахад Автомат шүүлтийн тоног төхөөрөмж ашиглаж байгаа бол түүнтэй хамт микрочип дамжуулагчийг ашиглана. Микрочип дамжуулагч технологи нь цагийг арваны нэг (1/10) секундын нарийвчлалтай бүртгэнэ.

12.3.2 Автомат шүүлтийн тоног төхөөрөмж ашиглаж байгаа эсэхээс үл хамааран, энэхүү дүрмийн 12.4-д заасны дагуу бүх тамирчдын цагийг хэмжиж бүртгэх хангалттай тооны цагчин шүүгчид болон гар цаг (watch)-ийг бэлтгэх ёстой.

12.3.3 Автомат шүүлтийн тоног төхөөрөмжийг холбооноос томилогдсон техникийн багийн албан хаагчдын хяналт дор ашиглана.

12.3.3.1 Автомат шүүлтийн тоног төхөөрөмж нь замыг дуусгасан тамирчин бүрийн барианы цаг болон байрлалыг бүртгэнэ. Эдгээр байрлалууд болон барианы видео бичлэгт үндэслэн Ерөнхий шүүгч нь түрүүлсэн тамирчин болон бүх тамирчны байрыг эцэслэн тогтооно.

12.3.3.2 Автомат шүүлтийн тоног төхөөрөмжөөр бүртгэгдсэн цаг болон тогтоогдсон байрлалуудыг үнэн зөв гэж үзэх бөгөөд тэдгээр нь барианы шүүгчид болон цагчин шүүгчийн бүртгэсэн цаг, тогтоосон байрлалаас давуу байдлаар тооцогдоно.

12.3.3.3 Хэрэв Автомат шүүлтийн тоног төхөөрөмж эвдэрч гэмтсэн, ажиллахгүй болсон эсвэл тамирчин Автомат шүүлтийн төхөөрөмжийг идэвхжүүлж чадаагүй тохиолдолд Ерөнхий шүүгч нь энэхүү дүрмийн 12.4-д заасан журмын дагуу тухайн тамирчны албан ёсны цаг болон байрыг тогтооно.

12.3.4 Хэрэв нэг буюу хэд хэдэн завсрын цаг хэмжих хаалга (intermediate timing gates) ашиглаж байгаа бол тэдгээрийг зам дээр усны гадаргуу дээрх хэмжилтээр хамгийн багадаа зургаан (6) метрийн өргөнтэй байхаар байрлуулах бөгөөд ингэснээр тамирчид замын сэлэх шугамаасаа хазайх шаардлагагүй байна.

12.4 Автомат шүүлтийн тоног төхөөрөмж ашиглаагүй эсвэл ашигласан ч эвдэрсэн тохиолдолд мөрдөх журам:

12.4.1 Хэрэв Автомат шүүлтийн тоног төхөөрөмж ашиглаагүй бол Ерөнхий шүүгч цагийг дараах байдлаар тогтооно:

12.4.1.1 Тамирчин замыг дуусгахад зарцуулсан цагийг гурван (3) цагчин шүүгч арваны нэг (1/10) секундын нарийвчлалтайгаар бүртгэнэ. Тухайн тамирчны албан ёсны цагийг дараах байдлаар тогтооно:

12.4.1.1.1 Хэрэв гурван (3) цагнаас хоёр (2) нь ижил цагийг бүртгэж, гурав дахь цаг өөр цагийг бүртгэсэн бол ижил хоёр цагийг тамирчны албан ёсны цаг гэж тэмдэглэнэ.

12.4.1.1.2 Хэрэв гурван (3) цаг бүгд өөр өөр цагийг бүртгэсэн бол, гурван цагийн дунд талын (завсрын) цагийг тамирчны албан ёсны цаг гэж тэмдэглэнэ.

12.4.1.1.3 Хэрэв гурван (3) цагнаас зөвхөн хоёр (2) нь ажиллаж, өөр цагийг бүртгэсэн бол хоёр цагийн дундажийг албан ёсны цаг гэж тэмдэглэнэ. Хэрэв дундаж нь секундйн зууны нарийвчлалтай байвал эцсийн цифрийг тэмдэглэхгүй бөгөөд цагийг дээш буюу доош тоймлохгүй.

12.4.1.1.4 Хэрэв зөвхөн нэг (1) цаг ажиллаж байвал тухайн цагийн утгыг ашиглана. Хэрэв гурван (3) цагийн аль нь ч ажиллахгүй бол Ерөнхий шүүгч тухайн тамирчны байрыг албан ёсны цаггүйгээр тогтооно.

12.4.2 Хэрэв Автомат шүүлтийн тоног төхөөрөмж ашигласан боловч нэг буюу хэд хэдэн тамирчны цаг эсвэл байрыг бүртгээгүй тохиолдолд Ерөнхий шүүгч:

12.4.2.1 Автомат шүүлтийн тоног төхөөрөмжөөр бүртгэгдсэн бүх цаг, байрыг болон цагчин шүүгчдийн бүртгэсэн бүх цаг, байрыг нэгтгэнэ.

12.4.2.2 Уралдааны албан ёсны байрыг дараах байдлаар тогтооно:

12.4.2.2.1 Тамирчны байрыг Ерөнхий шүүгч барианы видео бичлэгийн үндсэн дээр тогтооно.

12.4.2.2.2 12.4.2.2.1-д заасны дагуу, Автомат шүүлтийн төхөөрөмжөөр цаг болон байрлал бүртгэгдээгүй тамирчныг ижил уралдаанд цаг, байрлал бүртгэгдсэн бусад тамирчидтай харьцуулахад замаар.

12.4.2.2.3 Хэрэв тамирчинд Автомат шүүлтийн төхөөрөмжөөр цаг бүртгэгдсэн боловч байр бүртгэгдээгүй бол түүний байрыг 12.4.2.2.1-д заасан журмын дагуу тогтооно.

12.4.2.2.4 Хэрэв тамирчинд Автомат шүүлтийн төхөөрөмжөөр цаг болон байрлал аль аль нь бүртгэгдээгүй бол тухайн тамирчны байрлалыг Ерөнхий шүүгч барианы шүүгчдийн бүртгэлийг үндэслэн тогтооно.

12.5 Видео туслах шүүгч (VAR- Video Assistant Referee):

12.5.1 Видео туслах шүүгч нь уралдааны төгсгөлд Ерөнхий шүүгчид шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвшөөрөгдсөн техникийн албан хаагчаас Ерөнхий шүүгчид мэдээлсэн аливаа дүрмийн зөрчилтэй холбоотой зургийг цуглуулж, дахин хянах систем юм.

12.5.2 МУССХ-ны тэмцээнүүдэд Видео туслах шүүгчийн систем ашиглахыг эрмэлзэх ба ашиглаж байгаа тохиолдолд дүрс бичлэгийг хянах Видео хянах шүүгчийг томилно. Энэ томилгоо нь энэхүү дүрмийн 2.21-д заасан журмын дагуу хийгдэнэ.

АРВАН ГУРАВ. УСНЫ ЧАНАР БА ТЭМЦЭЭНИЙ ТАЛБАРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

13.1 Усны чанарын удирдамж:

13.1.1 Энэхүү дүрмийн 13.1-д заасан заавар нь МУССХ-ны тэмцээнүүд болон бэлтгэлийн талбарын зохион байгуулагчдад усны чанартай холбоотой асуудлаар удирдамж өгөх зорилготой. Энэхүү удирдамж нь усны бохирдлыг тодорхойлох, заасан микроорганизмын хүлцэх түвшинг тогтоох, ариун цэврийн үзлэг хийх загвар болон тэмцээний талбарын тохиромжтой байдлыг тодорхойлох нэгдсэн мэдээллийг агуулсан байна.

13.1.2 Усны чанарын талаархи үндсэн мэдээлэл:

13.1.2.1 МУССХ нь задгай усанд сэлэлтийн тэмцээнүүдийг нуур, гол болон бусад тогтмол устай орчинд ихэвчлэн 1-10 км зайд зохион байгуулна. МУССХ болон түүний задгай усанд сэлэлтийн Техникийн баг нь Спортын анагаах ухааны холбогдох байгууллагуудтай хамтран тамирчдын аюулгүй байдлыг хамгийн чухал зорилт болгон ажиллана.

13.1.2.2 Энэхүү дүрэм нь усны хэм, усны чанар, бусад бохирдол болон усны эрсдэл зэрэг эрүүл мэнд, аюулгүй байдлын олон хүчин зүйлсийг хамрах бөгөөд усны чанарт онцгойлон анхаарна.

13.1.2.3 Задгай усанд сэлэлтийн тамирчид усаар дамжих аливаа хорт бохирдолд амьсгалах, залгих (устай хамт залгих) болон арьсаар шууд хүрэлцэх замаар өртөх магадлалтай. Нүд, чих, хамар, ам, дээд амьсгалын замын салст бүрхэвч нь бохирдолтой усанд урт хугацааны турш орсон үед халдвар дамжуулах боломжтой.

13.1.2.4 Хэрэв бохирдсон ус их хэмжээгээр залгисан тохиолдолд гэдэсний системд ачаалал өгч, суулгалт гүйлгэлт болон бөөлжих шалтгаан болж болно. Гэсэн хэдий ч эдгээр үр дагавар нь голчлон тухайн микроорганизмын төрөл, концентраци, өртсөн хугацаа, мөн тамирчны дархлаа, эмзэг байдал зэрэг хүчин зүйлсээс хамаарна.

13.1.2.5 Үр дагавар нь хөнгөн болон дунд түвшний гэдэсний өвчлөл, чих, хамар, нүдний халдвар, зарим эмзэг хүмүүст амьсгалын өвчин гэх мэт байж болно. Гэвч ихэнх тохиолдолд шинж тэмдэг түр зуурын бөгөөд энгийн эмнэлгийн арга хэмжээ авснаар сайжирдаг. Гэвч ноцтой эмнэлгийн үр дагавар гарч болзошгүй тул тодорхой аюулгүй байдлын стандарт хангасан тэмцээний талбар нь тамирчдын эрсдэлийг бууруулна.

13.1.2.6 Бэлтгэл болон тэмцээний талбарын тохиромжтой байдлыг бактериологи ба ариун цэврийн хамтарсан үнэлгээгээр тодорхойлдог. Бактериологийн шинжилгээ нь илэрсэн бактерийг хэмждэг бол ариун цэврийн судалгаа нь харааны шалгалт, ус зайлуулах хоолой, үйлдвэрийн бохирдол зэрэг бусад бохирдлын эх үүсвэрийг тодорхойлно. Ариун цэврийн судалгаа нь мөн цаг агаарын нөхцөл, ялангуяа борооны талбарт үзүүлэх боломжит үр дагаврыг авч үздэг.

13.1.3 Усны шинжилгээний давтамж:

13.1.3.1 МУССХ-ны задгай усанд сэлэлтийн тэмцээнийг зохион байгуулагч нь талбарын дээжээс авсан усны чанарын шинжилгээний тайланг МУССХ-нд ирүүлэх ёстой. Үүнээс гадна зохион байгуулагч нь тэмцээний эхлэхээс хоёр (2) сарын өмнө, тэмцээний эхлэхээс долоо (7) хоногийн өмнө, тэмцээний эхлэхээс 48 цаг хүртэл хугацааны өмнө, мөн тэмцээний өдөр авсан шинжилгээний тайланг нэмэлтээр ирүүлэх шаардлагатай.

13.1.3.2 Тэмцээний өдөр авсан шинжилгээг тамирчдын өвчлөл үүсэх магадлалтай үед, гэнэт орсон бороо, бусад урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйлээс шалтгаалсан усны чанарын өөрчлөлтийг авч үзэхэд ашиглана. Усны шинжилгээний мэдээлэл нь зохих эмчилгээний арга хэмжээг тодорхойлоход чиглэнэ.

13.1.3.3 Усны дээжийг замын гурван (3) өөр цэгээс авч, баталгаажсан лабораториор шинжлэх ёстой. Хамгийн муу үр дүн нь нийт усны чанарыг тодорхойлох бөгөөд дараах талбайн хүлцэх түвшинг мөрдөнө.

13.1.3.4 Нуур голын усны чанарын хүлцэх түвшин:

13.1.3.4.1 pH 6–9-ийн хооронд байна.

13.1.3.4.2 Enterococci ≤ 200 cfu/100 mL байна.

13.1.3.4.3 E. coli ≤ 500 cfu/100 mL байна.

13.1.3.4.4 Нуур голын усанд замаг илэрсэн тохиолдолд, тэмцээний зохион байгуулагч нь цианобактерийн шинжилгээ хийлгэж, үр дүнг холбогдох орон нутгийн эрүүл мэндийн байгууллага баталгаажуулна. 100,000 эс/mL-аас бага байх хүлцэх түвшинг шаарддаг.

13.1.4 Ариун цэврийн үзлэг:

13.1.4.1 МУССХ-ны төлөөлөгч нь тэмцээний талбарт ариун цэврийн үзлэг хийх бөгөөд энэ нь голчлон субъектив нүдэн ажиглалтын судалгаа байдаг.

13.1.4.2 Энэ үзлэг нь тэмцээний талбарын бохирдол, ойр орчмын үйлдвэр, ферм, зочид буудал, хүчтэй бороо орсны дараах усны хэт урсгал зэрэг бусад эх үүсвэрээс ялгасны бохирдолд өртөх боломжтой эсэхийг тодорхойлно.

13.1.4.3 Мөн үзлэгт усны тогтоц, усны тунгалаг байдал, үнэр, замаг, усны гадаргуу дахь хөвөгч ургамал эсвэл тосон давхарга, бусад харагдах бохирдол зэрэг зүйлсийг тэмдэглэнэ. Ариун цэврийн өндөр, сайн, муу түвшний жишээг доорх хүснэгтэд үзүүлсэн.

Усны ариун цэврийн жишиг үнэлгээ:

Ариун цэврийн хяналтын үзүүлэлтүүд	Маш сайн	Сайн	Муу
Замаг	Байхгүй	Байхгүй	Байгаа

Гадаргуун бохирдол (жишээ нь тос, тоосон бүрхүүл)	Байхгүй	Байхгүй	Байгаа
Усны тунгалаг байдал	50 см гүн хүртэл харагдана	Бага зэрэг улингартай	Булинггартай
Үнэр	Байхгүй	Дунд зэрэг	Байгаа
Цаг агаарын нөлөө	Байхгүй	Байгаа боловч багасаж байгаа	Байгаа
Идэвхтэй усны амьтан	Байгаа	Байгаа	Байхгүй

13.1.4.4 Шируун бороо гэх мэт цаг агаарын үзэгдлийн нөлөөг нотлох боломжтой тохиолдолд, тэмцээнийг зохион байгуулагч нь баримтжуулсан нотолгоогоор усны “тунгалаг болох хугацаа”-г (clearance time) тооцоолж, тэмцээний талбар бичил организмын хүлцэж болох түвшинд буцахад шаардагдах хугацааг тодорхой заах ёстой.

13.1.4.5 Мөн үзлэгээр давлагаа, урсгал, ерөнхий хог хаягдал, усанд хөвж буй мод, чулуулаг зэрэг эрсдэл үүсгэж болох хүчин зүйлсийг илрүүлэх ёстой бөгөөд эдгээр нь зам тавихад саад болохоос гадна тамирчдыг гэмтээх эрсдэлтэй.

13.2. Задгай усанд сэлэлтийн тэмцээний талбарын тохиромжтой байдал

13.2.1 Тамирчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын тулд задгай усанд сэлэлтийн тэмцээний талбарын тохиромжтой байдлыг усны чанарын шинжилгээний дүн, ариун цэврийн үзлэгийн тайлан, урьдчилсан усны температур, орон нутгийн цаг агаарын нөлөөллийг харгалзан тогтооно. Үүний тулд задгай усанд сэлэлтийн тэмцээний талбарын тохиромжтой байдлыг тодорхойлоход дараах хүснэгтүүдийг ашигладаг.

13.2.2 Далай, тэнгис, давалгаа бүхий усны чанарын шийдвэр гаргах хүснэгтийг доорх хүснэгтэд заасан байна:

	Ариун цэврийн ангилал		
	Маш сайн	Сайн	Муу
Өмнөх 2 шинжилгээ E.coli <250 Enterococci <100	1	1	2
Сүүлийн шинжилгээ E.coli 250-500 Enterococci 100-200	2	2	3
Өмнөх 2 шинжилгээ E.coli 250-500 Enterococci 100-200	2	3	3
Сүүлийн шинжилгээ	4	4	4

E.coli > 500 Enterococci > 200			
-----------------------------------	--	--	--

13.2.3 Далай, тэнгис, давалгаа бүхий усанд зохион байгуулах тэмцээний усны тохиромжтой байдлыг хэрхэн тодорхойлохыг доорх хүснэгтэд заасан болно:

Усны чанарын ангилал	Тодорхойлолт
1	Маш сайн усны чанар E. coli <250 CFU/100мл эсвэл Enterococci <100 CFU/100мл, Ариун цэврийн үзлэг маш сайн/сайн, ширүүн бороо орох урьдчилсан таамаглал байхгүй
2	Сайн усны чанар E. coli <250 CFU/100мл эсвэл Enterococci <100 CFU/100мл, Ариун цэврийн үзлэгт зарим дутагдалтай эсвэл ширүүн бороо орох урьдчилсан таамаглалтай; эсвэл E. coli 250–500 CFU/100мл эсвэл Enterococci 100–200 CFU/100мл, Ариун цэврийн үзлэгт дутагдалгүй, Ширүүн бороо орох урьдчилсан таамаглал байхгүй
3	Дунд зэрэг усны чанар E. coli 250–500 CFU/100мл, Enterococci 100–200 CFU/100мл, ариун цэврийн үзлэг муу болон/эсвэл хүнд бороо урьдчилан таамаглагдсан
4	Муу усны чанар E. coli >500 CFU/100мл, Enterococci >200 CFU/100мл, Ариун цэврийн үзлэг муу болон Ширүүн бороо орох урьдчилсан таамаглалтай

13.2.4. Нуур, мөрний усны чанарын шийдвэр гаргах хүснэгтийг доорх хүснэгтэд заасан байна:

	Ариун цэврийн ангилал		
	Маш сайн	Сайн	Муу
Өмнөх 2 шинжилгээ E.coli <500 Enterococci <200	1	1	2
Сүүлийн шинжилгээ E.coli 500-1000 Enterococci 200-400	2	2	3
Өмнөх 2 шинжилгээ E.coli 500-1000 Enterococci 200-400	2	3	3
Сүүлийн шинжилгээ E.coli > 1000	4	4	4

Enterococci > 400			
-------------------	--	--	--

13.2.5. Нуур мөрөнд зохион байгуулах тэмцээний усны тохиромжтой байдлыг хэрхэн тодорхойлохыг доорх хүснэгтэд заасан болно:

Усны чанарын ангилал	Тодорхойлолт
1	Маш сайн усны чанар E. coli <500 CFU/100мл эсвэл Enterococci <200 CFU/100мл, Ариун цэврийн үзлэг маш сайн/сайн, ширүүн бороо орох урьдчилсан таамаглал байхгүй
2	Сайн усны чанар E. coli <500 CFU/100мл эсвэл Enterococci <200 CFU/100мл, Ариун цэврийн үзлэгт зарим дутагдалтай эсвэл ширүүн бороо орох урьдчилсан таамаглалтай; эсвэл E. coli 500–1000 CFU/100мл эсвэл Enterococci 200–400 CFU/100мл, Ариун цэврийн үзлэгт дутагдалгүй, Ширүүн бороо орох урьдчилсан таамаглал байхгүй
3	Дунд зэрэг усны чанар E. coli 500–1000 CFU/100мл, Enterococci 200–400 CFU/100мл, ариун цэврийн үзлэг муу болон/эсвэл хүнд бороо урьдчилан таамаглагдсан
4	Муу усны чанар E. coli >1000 CFU/100мл, Enterococci >400 CFU/100мл, Ариун цэврийн үзлэг муу болон Ширүүн бороо орох урьдчилсан таамаглалтай

13.2.6 Тэмцээн зохион байгуулах усны чанарын тохиромжит байдлыг тодорхойлох:

13.2.6.1 МУССХ-ны бүх задгай усанд сэлэлтийн тэмцээний ус нь 1-р түвшний (маш сайн усны чанар) шаардлагыг хангасан байхыг эрмэлзэнэ.

13.2.6.2 Гэхдээ зарим тохиолдолд МУССХ нь 2-р түвшний (сайн усны чанар) шаардлагыг хангасан усанд тэмцээнийг зохион байгуулах нь аюулгүй гэсэн шийдвэр гаргаж болно. Жишээ нь: Их бороо орсны улмаас усны чанар муудсан боловч эргээд хэвийн болох боломжтой нөхцөл байдал. Эсвэл ус нь хог, гадаргын бохирдолтой холбоотой ариун цэврийн шаардлага хангахгүй байгаа боловч эдгээр бохирдлыг цэвэрлэсний дараа дахин хэвийн ангилагдах боломжтой нөхцөл байдал.

13.2.6.3 Усны чанарын тохиромжит байдал болон тохиромжит байдлын талаар дахин гаргаж буй бүх шийдвэрийг задгай усанд сэлэлтийн Техникийн баг болон спортын анагаах ухааны байгууллага (эсвэл тэдний төлөөлөгчид) болон Эрүүл мэндийн ажилтантай хамтран гаргана.

13.2.6.4 МУССХ нь 3-р түвшний (дундаж усны чанар) болон 4-р түвшний (муу усны чанар) усны чанартай бол тус газрыг задгай усанд сэлэлтийн тэмцээн болон бэлтгэл сургуулилт зохион байгуулахад аюулгүй гэж үзэх боломжгүй.

13.3 Усны чанар эсвэл талбайн тохиромжит байдал хангалтгүй тохиолдолд, МУССХ нь тэмцээнийг өөрчлөх, хойшлуулах, эсвэл цуцлах бүх эрх мэдлийг дангаар хэрэгжүүлэх бөгөөд тэмцээн болон арга хэмжээг зохион байгуулах боломжит нөхцлийг үргэлжлүүлэн үнэлнэ.

АРВАН ДӨРӨВ. ЗАДГАЙ УСАНД СЭЛЭЛТИЙН ЭМНЭЛГИЙН БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГУУД

14.1 МУССХ-ны “Тэмцээний дүрэм”-ийн эмнэлгийн болон аюулгүй байдлын шаардлагууд дээр нэмээд задгай усанд сэлэлтийн тэмцээнүүдэд дараах эмнэлгийн ба аюулгүй байдлын шаардлагуудыг мөрдөж ажиллана.

14.2 Зохион байгуулагч нь тэмцээний талбарын Аюулгүй байдлын Төлөвлөгөө боловсруулах бөгөөд, шаардлагатай бол МУССХ-той хамтран сайжруулж, тэмцээнд хэрэгжүүлэх ёстой:

14.2.1 Аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж мөрдөнө:

14.2.1.1 Тэмцээнээс дөрвөн (4) долоо хоногийн өмнө зохион байгуулагч нь тэмцээний “Аюулгүй байдлын төлөвлөгөө”-г бүх холбогдох тэмцээний дүрмийн шаардлагад нийцүүлэн боловсруулж батлуулахаар ирүүлнэ.

14.2.1.2 Аюулгүй байдлын төлөвлөгөөг МУССХ зохих түвшинд хянаж, батлах, өөрчлөх, эсвэл татгалзах эрхтэй.

14.2.1.3 МУССХ нь Аюулгүй байдлын болон Эмнэлгийн төлөвлөгөөг хянаж, энэхүү төлөвлөгөөнүүд нь бүх холбогдох асуудлыг хамруулан үр дүнтэй ажиллаж байгаа эсэхэд хяналт тавин ажиллана.

14.2.1.4 Аюулгүй байдлын төлөвлөгөөнд МУССХ-ны Аюулгүй байдлын төлөөлөгчийг томилж, тэр нь зохион байгуулагч, орон нутгийн гишүүн холбооноос хараат бус байж батлагдсан төлөвлөгөө болон тэмцээний дүрмийн шаардлага хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавин ажиллана.

14.2.1.5 Аюулгүй байдлын төлөвлөгөөнд Ерөнхий шүүгч нь Аюулгүй байдлын Төлөөлөгч, Аюулгүй байдлын Албан тушаалтан, эсвэл Эмнэлгийн Албан тушаалтны зөвлөмжөөр, тамирчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай бол тэмцээнийг хойшлуулах, цуцлах, эсвэл өөрчлөх боломжтой талаар тусгана. .

14.2.1.6 Холбооны болон гишүүн клубуудын ямар ч тэмцээнийг батлагдсан “Аюулгүй байдлын Төлөвлөгөө”-гүйгээр МУССХ нь зөвшөөрөх буюу батлахгүй.

14.2.1.7 Тэмцээнээс таван (5) хоногийн өмнө хүртэл, зохион байгуулагч нь батлагдсан “Аюулгүй байдлын төлөвлөгөө”г өөрчлөхийг хүсвэл, энэ өөрчлөлтийг МУССХ-оор дахин батлуулах шаардлагатай.

Тэмцээнээс таван (5) хоногийн дотор зөвхөн зохион байгуулагчийн хяналтаас хамаарахгүй нөхцөл байдлаас шалтгаалан төлөвлөгөөг өөрчлөх шаардлага гарвал, мөн МУССХ-нд батлуулах хүсэлт гаргана.

14.2.2 Тэмцээний Аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх:

14.2.2.1 Тэмцээнийг баталгаажуулахтай зэрэгцэн, МУССХ нь тус тэмцээний Аюулгүй байдлын төлөөлөгчийг томилно. Энэ төлөөлөгч нь зохион байгуулагчаас хараат бус байна. Тэрээр тэмцээний үеэр тамирчид болон бусад оролцогчдын аюулгүй байдлын бүх асуудлыг ерөнхийд нь хариуцаж, “Аюулгүй байдлын төлөвлөгөө” болон тэмцээний дүрмийг тэмцээний явцад дагаж мөрдөж байгааг тусгайлан хариуцна.

14.2.2.2 Зохион байгуулагч нь задгай усанд сэлэлтийн тэмцээнд аюулгүй байдлын туршлагатай Аюулгүй байдлын албан тушаалтан болон Аюулгүй байдлын багийг томилж, тэмцээний бүх аюулгүй байдлын ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Аюулгүй байдлын багт нь тусгай бэлтгэлтэй орон нутгийн аврагчид орно. Тэд тэмцээний явцад аюулгүй байдлыг хангахад оролцоно.

14.2.2.3 МУССХ-ны Аюулгүй байдлын төлөөлөгч нь тэмцээний талбарыг шалгаж, Аюулгүй байдлын албан тушаалтан ба Аюулгүй байдлын багтай тэмцээн эхлэхээс хамгийн багадаа гурван өдрийн өмнө уулзаж, Аюулгүй байдлын төлөвлөгөө нь талбарын нөхцөлд хангалттай байгаа эсэхийг, мөн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авсан эсэхийг баталгаажуулна.

14.2.2.4 МУССХ-ны Аюулгүй байдлын төлөөлөгч нь Аюулгүй байдлын төлөвлөгөөг бүрэн, зөв хэрэгжүүлээгүй үед, эсвэл тамирчид болон бусад оролцогчдын аюулгүй байдлыг хамгаалахын тулд шаардлагатай тохиолдолд тэмцээнийг өөрчлөх, хойшлуулах, эсвэл цуцлах эрхтэй. Мөн Төлөөлөгч нь Аюулгүй байдлын албан тушаалтан, Эрүүл мэндийн албан тушаалтан, Ерөнхий шүүгчтэй зөвлөлдөж, тэмцээнийг өөрчлөх, хойшлуулах, цуцлах боломжтойг хэлэлцэж болно.

14.3 Аюулгүй байдлын төлөвлөгөө нь дараах шаардлагуудыг тусгасан байна:

14.3.1 Техникийн / Багийн ахлагчдын хурал:

14.3.1.1 Гишүүн клуб/байгууллагуудын багийн ахлагч нар Техникийн/Багийн ахлагчдын хуралд заавал оролцоно. Хэрэв багийн ахлагч эсвэл тамирчныг дэмжих бусад хүн Техникийн / Багийн ахлагчдын хуралд оролцох боломжгүй бол тухайн тамирчин өөрөө уг хуралд оролцоно.

14.3.1.1.1 Хэрэв тамирчин өөрөө эсвэл түүний гишүүн клубын багийн ахлагч эсвэл тамирчныг дэмжих хүн Техникийн/Багийн ахлагчдын хуралд оролцоогүй бол тухайн тамирчныг тэмцээний аль ч уралдаанд оролцуулахгүй бөгөөд түүний мэдүүлгийг цуцална.

14.3.1.2 Техникийн/Багийн ахлагчдын хурал дээр хэлэлцэх аюулгүй байдалтай холбоотой асуудлуудад дараах зүйлс багтаана:

Замын зохион байгуулалт болон болзошгүй эрсдлийн талаарх анхааруулга, усны түрлэг, урсгал болон усны бусад нөхцөл; усны амьтан; цаг агаарын нөхцөл; усны температур; усны чанарын нөхцөл; Шүүгчид болон Аюулгүй байдлын баг тамирчдыг хэрхэн хянах тухай; Аюулгүй байдлын завь, хэрэгслийн байрлал; талбай дээрх эмнэлгийн тусламжийн зохион байгуулалт болон эмнэлэгт хүргэх боломж; тусламж дуудах дохио (нуруугаараа хөвж, гараа өргөн тусламж хүсэх); мөн замыг яаралтай чөлөөлөх нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, үүнд холбогдох харааны болон дуут дохионы тайлбар орно.

14.3.2 Уралдаан бүрийн өмнө богино хэмжээний аюулгүй байдлын зааварчилгаа хийнэ. Энэ нь энэхүү дүрмийн 3.2.2-р зүйлийн дагуу явагдах бөгөөд тухайн уралдаанд оролцож буй бүх тамирчин уг зааварчилгаанд заавал оролцоно.

14.3.3 Тамирчдыг хянах болон шаардлагатай тохиолдолд аврах ажиллагаа:

14.3.3.1 Уралдааны туршид тамирчин бүрийг дор хаяж нэг Аюулгүй байдлын багийн гишүүн эсвэл шүүгч байнга шууд ажиглалтандаа байлгана. Замын зохион байгуулалт нь Аюулгүй байдлын багийн ажиглагчдыг тамирчдыг хянахын тулд хаана байрлуулахыг тодорхойлно. Жишээлбэл: Нуур цөөрөм зэрэг задгай усанд оролцогчдын тооноос хамааран тамирчин бүрийг хянах зорилгоор тусгай ажиглагч бүхий Аюулгүй байдлын завь, хэрэгслүүдийг байрлуулах нь хамгийн тохиромжтой. Харин нарийн сувагт зохион байгуулагдаж буй тэмцээний үед зам дээр олон Аюулгүй байдлын завь байрлуулах нь бодит бус байж болох тул Аюулгүй байдлын багийн ажиглагчид эргээр явж тамирчдыг дагаж хянах боломжтой. Зарим тохиолдолд Аюулгүй байдлын багийн ажиглагчдыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах нь илүү тохиромжтой байж болно.

14.3.3.2 Замын зохион байгуулалтаас шалтгаалан боломжтой тохиолдолд тэргүүлэгч тамирчин эсвэл тэргүүлэгч бүлгээс тасарч хоцорсон бүх тамирчдыг Аюулгүй байдлын завь шууд дагаж хянахуйц хангалттай тооны Аюулгүй байдлын завь байх ёстой. Аюулгүй байдлын завь нь тамирчин эсвэл тамирчдын бүлгийг аюулгүй ажиллагаанд шаардлагатай тохиолдолд шууд оролцох боломжтой хэмжээнд, зохистой зайнаас дагаж явна.

14.3.3.3 Зам дээр тамирчин аюулд орсон тохиолдлыг шууд илрүүлж, ажиглалт эсвэл мэдэгдлийн дараа нэн даруй аврах ажиллагаа эхлүүлэх боломжтой байхаар хангалттай тооны моторт Аюулгүй байдлын завь болон ойрын дэмжлэгийн Аюулгүй байдлын завь байрлуулсан байна. Тодорхой зайтайгаар (ихэнх замын зохион байгуулалтын хувьд 400 метр тутамд) хөдөлгөөнгүй байрласан Аюулгүй байдлын завь дээр CPR болон амь тэмцсэн үед үзүүлэх анхан шатны тусламжийн сургалттай

хүн байлгах ёстой. Мөн замын дагуу аврах зориулалтын буух цэгүүд хангалттай тоогоор байх бөгөөд тамирчин бүр эсвэл тамирчдын бүлэг бүрийн ойролцоо CPR болон амь тэмцсэн үед үзүүлэх анхан шатны тусламжийн сургалттай ажилтнууд хангалттай байхаар зохион байгуулна.

14.3.4 Аюулгүй байдлын холбоо, харилцаа:

14.3.4.1 Тэмцээний туршид МУССХ-ны Аюулгүй байдлын төлөөлөгч болон Аюулгүй байдлын ажилтан дараах хүмүүстэй шууд, хоёр талын шуурхай холбооны системээр холбогдох боломжтой байх ёстой. Үүнд: Тамирчдыг ажиглах үүрэгтэй бүх Аюулгүй байдлын багийн гишүүд; ойрын дэмжлэгийн болон Аюулгүй байдлын завь; тэжээлийн тавцан бүр дээр ажиллаж буй ажилтнууд; Ахлах эмч; Ерөнхий шүүгч; мөн зам дээр ажиллаж буй бусад шүүгчид.

14.3.4.2 Удирдлагын бүтэц дараах тогтолцоотой байна: МУССХ-ны Аюулгүй байдлын төлөөлөгч нь Аюулгүй байдлын ажилтантай шууд харилцана. Харин Аюулгүй байдлын ажилтан нь шаардлагатай тохиолдолд бүх аврагчид болон эмнэлгийн багийн ажилтнуудыг шууд дайчлах бүрэн эрхтэй бөгөөд тэдэнтэй шууд харилцана.

14.3.4.3 Тамирчдыг хянах үүрэгтэй Аюулгүй байдлын багийн гишүүд мөн бүх Аюулгүй байдлын завьтай шуурхай холбогдох боломжтой байх ёстой.

14.3.4.4 Шууд, хоёр талын шуурхай холбооны систем нь онцгой байдлын үед ашиглах зориулалттай тусгай нэг суваг эсвэл дугаартай байх ёстой бөгөөд мөн нөөц холбооны систем бэлэн байх шаардлагатай.

14.3.5 Тамирчдыг бүртгэж хянах:

14.3.5.1 Уралдаан эхэлснээс эхлэн хамгийн сүүлчийн тамирчин аюулгүйгээр барианд орж дуусах (эсвэл өөр байдлаар бүртгэгдэж баталгаажих) хүртэл бүх тамирчны бүртгэл, хяналтыг бүртгэл хариуцсан албан тушаалтан хариуцна. Тамирчид уралдаанаас гарсан эсвэл барианд орсон тохиолдол бүрт уралдаанд гарсан тамирчдын жагсаалтаас тухайн тамирчныг тэмдэглэн хасна.

14.3.5.2 Тамирчид уралдаанаас гарах (хасагдах, барианд орох болон бусад шалтгаанаар) тохиолдолд Бүртгэлийн ажилтанд заавал бүртгүүлсний дараа л замыг орхино.

14.3.5.3 Аюулгүй байдлын төлөвлөгөөнд шаардсан тохиолдолд тамирчид электрон хяналтын төхөөрөмж зүүх ёстой.

14.3.6 5 км-ээс урт уралдаанд дор хаяж 2.5 км тутамд байрлах хөвөгч тэжээлийн тавцан эсвэл суурин тэжээлийн цэгүүд байх ёстой.

14.3.7 Энэхүү дүрмийн 12.2.1-р зүйлд заасны дагуу усны чанарыг багтаасан тухайн тэмцээний талбарын тохиромжтой эсэхийг баталгаажуулсан орон нутгийн эрх бүхий байгууллагын дүгнэлт гарсан байх ёстой. Төлөвлөгөө батлагдсантай холбоотойгоор

олгогдсон уг дүгнэлтийг уралдаан болох өдрөөс 48 (дөчин найм) цагийн дотор шинэчилсэн байна.

14.3.8 Уралдааны зам нь зөвхөн бага зэргийн урсгал эсвэл түрлэгтэй байж болох бөгөөд бөгөөд аюултай аливаа саад, бохирдол, мөн аюултай усны амьтангүй байх ёстой.

14.3.9 Эмнэлгийн үйлчилгээ:

14.3.9.1 Зохион байгуулагч нь тэсвэрийн төрлийн тэмцээний үеэр эмнэлгийн тусламж үзүүлж байсан туршлагатай эмчийг Ахлах эмчээр томилно. Эмнэлгийн багийн бусад гишүүд нь суурин байрласан Аюулгүй байдлын завь болон тэмцээний талбай дээрх бусад эмнэлгийн цэгүүдэд ажиллахуйц, яаралтай тусламжийн (анхан шатны амь тэнссэн үед үзүүлэх тусламж, CPR) сургалттай хангалттай тооны хүмүүс байна.

14.3.9.2 Талбай дээрх эмнэлгийн цэг нь анхан шатны яаралтай тусламж болон гэмтлийн үед ашиглах тоног төхөөрөмж, автомат зүрхний дефибриллятор (AED), мөн Аюулгүй байдлын төлөвлөгөөнд заасан шаардлагын дагуу халаах эсвэл хөргөх төхөөрөмжтэй байна.

14.3.9.3 Түргэн тусламжийн машин тэмцээний талбай дээр бэлэн байх эсвэл талбайгаас 5 (тав) минутын дотор ирэх боломжтой байдлаар дуудах боломжтой байна. Мөн нэмэлт (нөөц) түргэн тусламжийн машин талбай дээр бэлэн байх эсвэл талбайгаас 15 (арван тав) минутын дотор ирэх боломжтой байхаар бэлтгэхийг зөвлөж байна.

14.3.9.4 Хэрэв тэмцээний талбайгаас яаралтай тусламжийн тасагтай хамгийн ойрын эмнэлэг хүртэл түргэн тусламжийн машинаар хүрэх хугацаа 1 (нэг) цагаас илүү бол Аюулгүй байдлын төлөвлөгөөнд нисдэг тэргээр тээвэрлэх боломжийг заавал судалж тусгасан байх ёстой.

14.3.10 Бэлтгэлийн үе, уралдааны өмнөх халаалт, уралдааны дараах суллах сэлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангах зохицуулалт. Зохион байгуулагч нь тогтоосон бэлтгэлийн цагийн хуваарийн үеэр, уралдааны өмнөх халаалт болон уралдааны дараах суллах сэлэлтийн үед зам дээр Аюулгүй байдлын багийн хангалттай хяналтыг (Safety Crew) зохион байгуулах ёстой. Тамирчид бэлтгэлийн үеэр Аюулгүй байдлын завьгүйгээр усанд орохыг хориглоно.

14.3.11 Замыг яаралтай чөлөөлөх төлөвлөгөө. Онцгой байдлын үед бүх тамирчин, Техникийн албан тушаалтнууд болон бусад ажилтнуудыг уснаас гаргаж аюулгүй байрлалд хүргэх ажиллагааг хэрхэн зохион байгуулахыг уг төлөвлөгөөнд тодорхой тусгасан байна.

АРВАН ТАВ. ХАВСРАЛТУУД


15.1 Хавсралт 1 – Замын зураглал


15.2 Хавсралт 2 – Зам дагуу байрлах завтнуудын байршлын зураглал

15.3 Хавсралт 3 – Гарааны тавцан, Тэжээлийн тавцан, Хөвөгч тэмдэглэгээний зураглал

15.4 Хавсралт 4 - Барианы болон дундын хаалганы зураглал

Хавсралт 1 - Замын зураглал






- | | |
|----------------------------------|--------------------|
| 1 Гарааны тавцан | 7 Тэжээлийн тавцан |
| 2 Барианы хаалга | 8 Цаг хэмжих өрөө |
| 3 Дундын хаалга | |
| 4 Эргэлтийн хөвүүр | |
| 5 Чиглүүлэх хөвүүр | |
| 6 Эргэлтийн шүүгчийн тавцан/завь | |

Усны нөхцөл

- Тэмцээний зам нь зөвхөн бага зэргийн урсгал эсвэл түрлэгтэй байж болох бөгөөд давстай эсвэл цэнгэг ус байж болно.
- Замын аль ч цэгт усны хамгийн бага гүн нь 1.40 метр байна.
- Усны температур хамгийн багадаа 16°C, хамгийн ихдээ 31°C байна. Тэмцээний өдөр гараанаас 2 цагийн өмнө, замын дунд хэсэгт 40 см-ийн гүнд хэмжиж шалгана. Энэ шалгалтыг Зохион байгуулах хорооны төлөөлөгчийг байлцуулан хийнэ.


Хавсралт 2 - Зам дагуу байрлах завьнуудын байршлын зураглал



- 1 Кауак завь- Баруун тал
- 2 Кауак завь- Зүүн тал
- 3 Кауак завь- Эргэлт-1 Баруун тал
- 4 Кауак завь- Эргэлт-2 Зүүн тал
- 5 Завь- Ерөнхий шүүгч+ залуурч
- 6 Завь- Шүүгч-1 + залуурч
- 7 Завь- Шүүгч-2 + залуурч
- 8 Тавцан эсвэл завь- Эргэлтийн шүүгч-1
- 9 Тавцан эсвэл завь- Эргэлтийн шүүгч-2
- 10 Тавцан эсвэл завь- Эргэлтийн шүүгч-3
- 11 Тавцан эсвэл завь- Эргэлтийн шүүгч-4
- 12 Завь- Зам хариуцсан ажилтан
- 13 Завь- Эмч + залуурч + 1 аврагч
- 14 Завь- Аюулгүй байдлын ажилтан + залуурч + 1 аврагч
- 15 Завь- Мэдээллийн ажилтан + залуурч
- 16 Завь- Тусламжийн эмч + залуурч
- 17 Завь- Тусламжийн эмч + залуурч

*** Бүх завь залуурчтай байна**

Хавсралт 3 - Гарааны тавцан, Тэжээлийн тавцан, Хөвөгч тэмдэглэгээний зураглал



Хавсралт 4 - Барианы болон дундын хаалганы зураглал

